

АЛСЫН ХАРАА

2050

МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ  
ХӨГЖЛИЙН БОДЛОГО

УЛААНБААТАР БА  
ДАГУУЛ ХОТ

9

ᠠᠯᠤᠰᠢᠨ ᠬᠠᠷᠠᠭ᠎ᠠ  
ᠲᠣᠮᠤᠮᠤᠯᠤᠯ ᠤᠯᠤᠰᠢᠨ ᠤᠷᠲᠤ ᠬᠤᠭᠠᠳᠤᠴᠠᠭᠠᠨᠢ  
ᠬᠥᠭᠢᠵᠢᠢᠶᠢᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭ᠎ᠠ

ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠪᠠ  
ᠳᠠᠭᠤᠯ ᠬᠣᠲ



# АЛСЫН ХАРАА 2050

МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ  
ХӨГЖЛИЙН БОДЛОГО



УЛААНБААТАР БА  
ДАГУУЛ ХОТ

9

Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй,  
хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ.



АЛСЫН ХАРАА  
2050

МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ  
ХӨГЖЛИЙН БОДЛОГО

## УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ

### Ерөнхий редактор:

Пүрэвийн ЗОХИХСҮРЭН  
Баянгэрэлийн БАТБААТАР

### Редакцын баг:

Пүрэвийн ЗОХИХСҮРЭН  
Ванчигийн БАТЦЭЦЭГ  
Өлзийбүрэнгийн ЖАМЪЯН  
Ганболдын БАЯРЦЭЦЭГ

### Зөвлөх:

Жанцангийн БАТБАЯСГАЛАН  
Цэрэндашийн ТУЛГА  
Адъяагийн МӨНХБОЛД  
Басбишийн ОЮУНТУЯА  
Гомбосүрэнгийн ДАРХАНЧУЛУУН  
Амгаагийн БАТТӨМӨР  
Баярсайханы АМАРСАНАА

### Туслан гүйцэтгэсэн:

Цэдэндамбын МЯДАГМАА

### Дизайнер:

Нямжавын БЯМБАЦОГТ  
Жаргалсайханы МӨНХСАЙХАН

### Гэрэл зураг:

МРА.МН  
Жамбалын БАТБААТАР /Баку/  
Хишигтогтохын ТҮШИГ

### Хавтасны зураг:

Батбаатарын ЦОЛМОНБАЯР

Улаанбаатар хот 2022 он

Copyright © ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Энэхүү бүтээлийн зохиогчийн эрхийг хуулиар хамгаалсан болно. Бүтээлийг ашгийн бус зорилгоор олон нийтэд түгээх, хуваалцах, ашиглах, хэрэглэх эрхтэй бөгөөд гагцхүү эх сурвалжийг дурдана уу.

Хэвлэлийн эхийг Нэпко хэвлэлийн газарт бэлтгэж,  
"Мөнхийн үсэг" ХХК-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ISBN: 978-9919-511-63-0



## ГАРЧИГ

ШИНЭ УЛААНБААТАР	8
ХҮН ТӨВТЭЙ ХОТ	16
ОРЧИН ТӨВТЭЙ ШИЙДЭЛ	24
ТӨЛӨВЛӨЛТ ТӨВТЭЙ ХӨГЖИЛ	34
ХОТЫН САЙН ЗАСАГЛАЛ	44
ДАГУУЛ ХОТ	52

## УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот 2050 онд улс орныхоо нийгэм, эдийн засгийн гол зангилаа, хүн амын төвлөрөл бүхий Метрополитан хот болох нь зайлшгүй билээ. Улсын нийслэлийг өөр газарт шинээр нүүлгэн шилжүүлсэн ч энэхүү нөхцөл байдлыг өөрчлөх боломжгүй юм. Иймээс ирэх 30 жилд Нийслэлд урт хугацааны, орчин үеийн хот төлөвлөлтийн үндсэн агуулгыг багтаасан хөгжлийн шийдэл хэрэгтэй. Иймд Улаанбаатар хотыг амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй хот болгон хөгжүүлэх зорилго дэвшүүлсэн билээ.

Монгол Улсын газар нутгийн 0.3 хувийг эзэлдэг Улаанбаатар хотод нийт хүн амын 47.6 хувь нь амьдарч байна. Хүн амын төвлөрлөөс үүдэн агаар, орчны бохирдол, авто замын түгжрэл, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хүртээмжгүй байдал зэрэг олон хүндрэл тулгарч байна. Улаанбаатарын хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудлыг хотын удирдлага бие даан шийд гээд орхих бус урт хугацааны хөгжлийн бодлогодоо тусгаж, шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсэн. Иймд Улаанбаатар хотыг шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөж, орчин үеийн шийдэл бүхий, нийгэм-эдийн засгийн үр өгөөжтэй, иргэндээ ээлтэй хот болгон цогцлоохоор “Улаанбаатар ба дагуул хот” гэсэн зорилгыг тусгалаа.

Энэ том зорилгын эхлэл нь хууль, эрх зүйн таатай орчин, хөрөнгө санхүүгийн бие даасан байдал бөгөөд 2021 онд Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчлэн батлав. Уг хуулиар хот өөрийн хууль эрх зүйн болон санхүүгийн бие даасан байдлаа баталгаажуулснаар цаашид төлөвлөсөн хөгжил, зорилгоо хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлж байна.



УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ

# ШИНЭ УЛААНБААТАР

Улсын нийслэл Улаанбаатар хотын хөгжил бол Монгол Улсын нүүр царай. Энэ хот хэрхэн хөгжиж, өөрчлөгдөн шинэчлэгдэж буй байдлаас манай улсын хөгжлийг хэмжиж болно. Аливаа улсын нийслэл хот нь бие даасан хот гэхээсээ илүү тухайн улсын өнгө төрх болж, гадаадын жуулчдын сонирхлыг татдагийн хувьд түүний эдийн засгийн хөгжлийн бодлогыг тусгайлан авч үзэж, онцлог зохицуулалтын хүрээнд дэмжих олон улсын жишиг бий.

Монгол Улсын Үндсэн хуульд Улаанбаатар хотыг улсын нийслэл хэмээн заасан. Нийслэл нь нийгэм, эдийн засгийн төдийгүй соёл, спорт, боловсролын төв учраас Монгол хүн бүр эрдэм боловсрол эзэмшиж, ажил хөдөлмөр эрхлэн, дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхахын тулд нийслэлд амьдран суурьшихыг эрмэлзэж байна. Улаанбаатар хотод өдгөө улсын нийт хүн амын 47.6 хувь нь амьдарч, дотоодын нийт бүтээгдэхүүний 65 хувь нь төвлөрч байна.

Гэр хороололд суурьшиж буй айл өрх, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг дулаанаар хангаж буй төрөл бүрийн хийц, хүчин чадал бүхий 3,000 гаруй халаалтын зуухнаас гарч буй утаа тортог нь агаарын бохирдлын 80 гаруй хувийг эзэлдэг бол авто тээврийн хэрэгсэл, дулааны цахилгаан станц, хог хаягдал, хөрснөөс дэгдэх тоос зэрэг нь үлдсэн 20 хувийг ялгаруулдаг.

Улаанбаатар хотод жилд дунджаар 1.1 сая тонн хог хаягдал гарч, 95 хувийг төвлөрсөн цэгт дарж булшилдаг, хог хаягдал дахин боловсруулах жижиг, дунд үйлдвэрүүд 2016 оноос эхлэн эрчимтэй байгуулагдаж, иргэд оршин суугч, аж ахуйн нэгж байгууллагууд нь хог хаягдлаа эх үүсвэр дээр ангилан ялгах ажлыг эхлүүлээд байна. Хотын хэмжээнд шатахуун түгээх станц, нефтийн агуулахууд 6.37 га талбайд байршсанаар хүрээлэн буй орчныг нефтийн бохирдлоор бохирдуулж байна.

Нийслэл хот нь түүхэн хөгжлийнхөө явцад 1954 онд анхны ерөнхий төлөвлөгөөг боловсруулснаас хойш 1963, 1971, 1986, 2002, 2013 онуудад тухайн үеийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн боловсруулсан зургаан



ерөнхий төлөвлөгөөний дагуу хөгжиж, өнөөгийн дүр төрхөө олжээ. Хэдий хот төлөвлөлттэй байсан ч тэр бүхэн ямар нэг байдлаар гажуудсаар хүн амын хэт төвлөрөл, агаар орчны бохирдол зэрэг сорилт бэрхшээлийг бий болгожээ.

Сүүлийн 10 жилийн дотор Улаанбаатарын бүсийн хүн ам 558.2 мянгаар өссөн. Үүний дотор Улаанбаатар хотын хүн ам 437 мянгаар нэмэгдсэн нь Дархан хотын хүн амын тооноос 5.7 дахин, Эрдэнэтийн хүн амаас 5.1 дахин олон, Өвөрхангай, Булган, Говьсүмбэр, Сүхбаатар, Говь-Алтай, Дундговь, Архангай гэсэн долоон аймгийн хүн амыг нийлүүлсэнтэй тэнцэж байна. Ийнхүү нийслэл хотын оршин суугчдын тоо богино хугацаанд асар хурдан нэмэгдэж, хүн амын хэт төвлөрөл үүссэнээс хот төлөвлөлтийн бодлого бүрмөсөн алдагдаж, түүнийг даган нийгэм, эдийн засгийн хүндрэл бэрхшээлүүд үүссэн. Тиймээс шинэ Улаанбаатар хотыг шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөх шинэ зорилго дэвшүүлэв. Ингэхдээ иргэндээ ээлтэй, төлөвлөлт төвтэй, орчин үеийн шийдэлтэй, сайн засаглалтай хотыг байгуулах зорилго дэвшүүллээ. Хотын төвлөрлийг сааруулж, нийгэм-эдийн засгийн салбар бүрийн тулгуур болсон дагуул хотуудыг шинээр байгуулан, бие даасан хот болгон хөгжүүлэхээр бодлогын баримт бичигтээ тусгаад байна. Өдгөө бидэнд түүх, уламжлалыг

#### Төвлөрөл

Боловсрол, үйлдвэр үйлчилгээ, эдийн засаг, эрүүл мэндийн байгууллагууд нийслэл хотод төвлөрсөн нь Улаанбаатар хотыг чиглэх их нүүдлийн нэгэн шалтгаан болжээ.

Зураг 1. Улаанбаатар хотын хэт төвлөрөл



хослуулсан шинэ зууны орчин үеийн хотыг бүтээн байгуулах нийгмийн шаардлага тулгараад байна. Хот төлөвлөлтийн амин сүнс нь дэд бүтэц, газар доорх байгууламжийн асуудал байдаг. Хотын иргэдийн тав тухтай амьдралын эх сурвалж нь найдвартай дэд бүтцийн шийдлээс шууд хамааралтай.

Улаанбаатар хотын инженерийн дэд бүтцийн эх үүсвэрүүдийн хүчин чадал боломжит хэмжээнд байгаа боловч дамжуулах, түгээх сүлжээний хүртээмж харилцан адилгүй, насжилт өндөртэй, тоног төхөөрөмжүүд хуучирсан, сүлжээний алдагдал их байна.

Сонгууль дагасан циклээс үүдэлтэйгээр Засгийн газар, хотын удирдлагууд урт хугацааны асуудлыг шийдвэрлэхэд бус ил харагдаж буй байдалд анхаарч ирсний нэг жишээ нь Улаанбаатар хотын газар доорх байгууламжийн өнөөгийн нөхцөл байдал юм. Тухайлбал, дулааны станцуудын насжилт 35-60 жил, цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний насжилт 32-62 жил болсон нь газар доорх байгууламжийг шинэчлэх, инженерийн дэд бүтцийг өргөжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалт шаардлагатай түвшинд хийгдэлгүй явсаар ирснийг харуулж байна.

Дэд бүтэц

Өдөр бүр өргөжин тэлж буй хүн амын хэрэгцээг төвлөрсөн сүлжээгээр хангах нь хүндрэлтэй болсон учир Улаанбаатар хотод бие даасан, хэсэгчилсэн инженерийн хангамжийг байгуулж эхэллээ.

Зураг 2. Улаанбаатар хотын дэд бүтэц



**ДЦС-2 1961 он (61 жил)**  
ХҮЧИН ЧАДАЛ: **60 Гкал/ц**  
ХОЛБОГДСОН АЧААЛАЛ: **97.6 Гкал/ц**  
ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ АЧААЛАЛ: **5.5 Гкал/ц**  
ЧАДЛЫН ДУТАГДАЛ: **-43.1 Гкал/ц**



**ДЦС-4 1983 он (39 жил)**  
ХҮЧИН ЧАДАЛ: **1,373 Гкал/ц**  
ХОЛБОГДСОН АЧААЛАЛ: **1,614.6 Гкал/ц**  
ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ АЧААЛАЛ: **279.05 Гкал/ц**  
ЧАДЛЫН ДУТАГДАЛ: **-520.7 Гкал/ц**

**ДЦС-3 1968 он (54 жил)**  
ХҮЧИН ЧАДАЛ: **585 Гкал/ц**  
ХОЛБОГДСОН АЧААЛАЛ: **995.5 Гкал/ц**  
ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ АЧААЛАЛ: **112.21 Гкал/ц**  
ЧАДЛЫН ДУТАГДАЛ: **-522.7 Гкал/ц**


**Амгалан ДС 2015 он (7 жил)**  
ХҮЧИН ЧАДАЛ: **300 Гкал/ц**  
ХОЛБОГДСОН АЧААЛАЛ: **458.5 Гкал/ц**  
ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ АЧААЛАЛ: **76.66 Гкал/ц**  
ЧАДЛЫН ДУТАГДАЛ: **-235.2 Гкал/ц**

2025 оны түвшинд **3,874** ↑  
Гкал/ц

Эх сурвалж: Эрчим хүчний яам, 2022



Зураг 3. Улаанбаатарын таталцал, нөлөөллийн бүс



Эх сурвалж: НЗДТГ, 2021

Бүсийн нутаг дэвсгэрт орших олон улсын тээвэр логиستيкийн дэд бүтцийг өргөтгөн шинэчилж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ. Улаанбаатар хот орчмын бүсийг байгаль орчин нутаг дэвсгэрийн онцлог, хөгжлийн одоогийн түвшин, ирээдүйн чиг хандлагыг харгалзан, цаашид хөгжүүлэх үүргийн ялгаатайгаар 5 бичил бүс, 5 бичил төв болгон хуваасан. Эдгээр бүс нутагт инженерийн болон зам тээврийн дэд бүтцийн эх үүсвэрүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөтгөн шинэчлэх, шинээр байгуулах бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээ хэрэгжүүлнэ.

Цаашид төвлөрсөн сүлжээгээр хотын суурьшлын хэсгийг бүрэн хангах боломжгүй учраас бие даасан хэсэгчилсэн инженерийн хангамжийн шийдлийг хөгжүүлэх, шинэ техник технологийг нэвтрүүлэх шаардлага тулгарч байна.

Улаанбаатар хотын иргэдээс санал асуулга авах, нийгэм, эдийн засгийн үзүүлэлт, тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйлийг тооцох замаар ирээдүйн төлөв байдлыг загварчилж харуулсан Нийслэлийн систем динамик загварыг тодорхойлох, мэргэжлийн байгууллага, эрдэмтэн, судлаачдын санал, зөвлөмжийг авах зэргээр Улаанбаатар хотод шийдвэрлэх шаардлагатай тулгамдсан асуудлыг тодорхойлж, бодлогын зорилго, зорилт, зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээг тодорхойлохыг зорьсон.

Нийслэлийн иргэдээс авсан санал асуулгын үр дүнгээр нэн тэргүүнд шийдвэрлэвэл зохих асуудлуудын нэгдүгээрт гэр хорооллыг үе шаттайгаар инженерийн шугам сүлжээнд холбон барилгажуулах, хоёрдугаарт нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг

Зураг 4. Улаанбаатар хотын систем, динамик загвар

## НИЙСЛЭЛИЙН СИСТЕМ ДИНАМИК ЗАГВАР

Нийгэм эдийн засгийн үзүүлэлт, тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйлийг тооцох замаар ирээдүйн төлөв байдлыг загварчилж харуулдаг математикийн ШУ-ны орчин үеийн дэвшилтэт арга юм.

### 01. УБХЕТ/ЧХ-2030 ХЭРЭГЖИЛТ

**хэрэгжилтийн байдал - 29.6%**  
мониторинг сайжруулах шаардлага

### 02. СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ

мониторинг сайжруулахад математик загварчлал ашиглах **"Vensim" программ** ашиглан хотын систем динамик загвар тодорхойлох

### 03. ЗАГВАР ЗАГВАРЧЛАЛ

**4** үндсэн, **45** дэд сэдвийн **54** сектор, **89** дифференциал тэгшитгэл бүхий **2000** гаруй хувьсагч параметртэй загварчлал хийж, хотын эдийн засгийн үйл ажиллагааны загвар боловсруулан хяналт тавих боломж

### 04. ХҮРЭХ ҮР ДҮН

Ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих замаар гүйцэтгэлийн үр дүнг сайжруулж, **"АМЬДРАХ ТААТАЙ ОРЧИН БҮРДСЭН ХОТ"** болно.





нэмэгдүүлэх, гуравдугаарт зам тээврийн сүлжээний хүртээмжийг нэмэгдүүлэх саналууд оржээ.

Иймээс Улаанбаатар хотын хөгжлийг хүн төвтэй хот, орчин төвтэй шийдэл, төлөвлөлт төвтэй шийдэл, хотын сайн засаглал, дагуул хот гэсэн таван цогц зорилтын хүрээнд тодорхойлсон.

Үүнээс гадна хотын хөгжлийн үзүүлэлтийг олон улсын жишгийн дагуу аргачлалаар дараах 8 үзүүлэлтээр үе шат бүхэнд хэмжихээр тооцож байна.


1. Хүрээлэн байгаа орчин
2. Дэд бүтэц
3. Амьжиргааны зохистой түвшин
4. Боловсрол
5. Эрүүл мэнд
6. Соёл, урлагийн үйлчилгээ
7. Хувь хүний аюулгүй байдал
8. Засаглалын үзүүлэлт (индекс)



Улаанбаатар хотын хүн ам 2050 онд 2.5 саяд хүрэх тооцоолсон судалгаа бий. Иймээс нийслэлд тулгарч буй асуудлуудыг шийдэх, зайлшгүй шаардлагатай.



## СИСТЕМ ДИНАМИК ЗАГВАРЧЛАЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ



үндсэн салбар:	4
дэд салбар:	45
сектор:	54
дифференциал тэгшитгэл:	89
хувьсагч параметр:	1,000 гаруй

### ДЭЛХИЙН ХОТУУДЫН ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА

Аливаа хот гэдэг хүн ам ихтэй, барилга байшин цогцлоон суурьшсан томоохон хэмжээний суурин газар бөгөөд тухайн улс орны түүх, шашин, соёлын өвөрмөц байдал, нийгэм, эдийн засгийн үзүүлэлт зэрэг олон чухал шинж чанарыг илтгэдэг засаг захиргааны нэгж билээ.

Дэлхий дахинд аж үйлдвэржилттэй уялдан сүүлийн хэдэн зуун жилд хотжилт хурдацтай явагдаж, хүмүүсийн орлого өсөхийн хэрээр хотууд улам томорч, барилга байгууламжийн тоо нягтаршил огцом нэмэгдсээр иржээ. XIX зуунд голдуу аж үйлдвэрийн хотууд цэцэглэн хөгждөг байсан бол XX зуунаас хотжилт өргөн хүрээнд эрчимтэй явагдаж эхэлсэн. 1900 онд дэлхийн хүн амын 13 хувь нь хотод амьдардаг байсан бол, зууны төгсгөлд 47 хувь, зарим орнуудад 90 хувиас давах болжээ. Хотын хүн ам энэ эрчээрээ өссөөр байвал 2050 он гэхэд хүн төрөлхтний 70 хувь нь хот суурин газарт амьдарна гэж НҮБ тооцоолсон байдаг.

Дэлхийн хотууд нийт хуурай газрын ердөө гуравхан хувийг эзэлдэг хэдий ч эрчим хүчний хэрэглээний 60-80 хувийг зарцуулж, хүлэмжийн хийн 75 хувийг бий болгодог ажээ. Тиймээс НҮБ-аас дэлхийн улс орнуудыг хүн амын хэрэглээний тогтвортой хангамжийг бий болгох, агаар орчны бохирдлыг бууруулах, ногоон, эрүүл хот бий болгохыг уриалдаг. Орчин үеийн гэгдэх хотуудын гол шалгуур үзүүлэлтийг эрүүл, эко, тогтвортой байдлаар нь дүгнэж байна.

#### Ирээдүйн нийслэл

Сүүл хотыг байгаль орчинд ээлтэй, амьдрах нөхцөлийг тэтгэсэн салхины эрчим хүчээр хангасан төсөөллийн зураглал





Дэлхийн хүн амын өсөлт, түүнтэй холбоотой хотжилт тэлж байгаа нь нэг талаас боломж боловч нөгөө талаас олон сорилтуудыг үүсгэж, хотын ногоон хөгжил, байгаль орчин, нийгмийн асуудлуудыг шийдэхэд хүндрэл бэрхшээл учирч байгаа тул НҮБ-ын зүгээс дэлхийн хотуудад ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлэхийг дэмжихэд чиглэсэн бодлого баримталж байна.

2015 оны есдүгээр сарын 25-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн IV бүгд хуралдаанаас баталсан Тогтвортой хөгжлийн зорилго 2030-д хотын ногоон хөгжлийг хангахад чиглэсэн сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг нэмэгдүүлэх, экологийн цэвэр эрчим хүчний технологийг хөгжүүлэх, хөрөнгө оруулах, агаарын чанар, хог хаягдлын менежментийг сайжруулах, бүс нутгийн хөгжлийг дэмжих, хот болон хөдөө орон нутаг хоорондын эдийн засаг, нийгэм, байгаль орчны эерэг холбоог бэхжүүлэх, үндэсний бодлого, стратеги, төлөвлөлтөд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлыг тусгах зэрэг асуудлыг зорилт болгон тусгасан байдаг.

Өдгөө дэлхийн өнцөг булан бүрд байгальд ээлтэй, тогтвортой хотын хөгжлийг бий болгохоор зорих болсон ба Arcadis компани жил бүр гаргадаг Дэлхийн хамгийн тогтвортой хотын жагсаалтыг 2018 онд Английн Лондон хот тэргүүлж, Шведийн Стокхолм, Германы Эдинбург, Сингапур, Австрийн Вена хотууд удаалжээ. Жагсаалтыг гаргахдаа тухайн хотын хүн ам, байгаль орчин, эдийн засаг гэх үндсэн гурван үзүүлэлтийн тогтвортой хөгжилд үзүүлж буй нөлөөг шалгуур болгожээ. Эдинбург хот 2016-2018 онд нийт өрхийн хог хаягдлын 42.6 хувийг дахин боловсруулсан байна.

Стокхолм хот 2040 он гэхэд органик түлшний хэрэглээ зонхилсон уур амьсгалд ээлтэй хот болох “Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг төлөвлөгөө”-г баталжээ.

Цэцэрлэгт хүрээлэн дэх хот гэгддэг Сингапур улсын нутаг дэвсгэрийн бараг 50 хувь нь ногоон байгууламжаас бүрдэх 72 га цэцэрлэгт хүрээлэн, ногоон ханаараа алдартай бөгөөд эрчим хүчний үйлдвэрлэлийн 95 хувийг байгалийн хийнээс гаргаж авдаг, нүүрсхүчлийн хийг хамгийн бага хэрэглэдэг дэлхийн 20 орны нэг юм.

Дэлхийн хотуудын туршлагаас харахад ногоон хот төлөвлөлт нь судалгаа, шинжилгээ, техник технологийн дэвшлийг үр дүнтэй ашиглах, тэдгээрийг олон улс болон бүс нутгийн хамтын ажиллагаа, судалгаа, шинжилгээ, ногоон эдийн засгийг дэмжсэн бодлого, хот төлөвлөлтөд тулгуурлан боловсруулах чиг хандлага орчин үед давамгайлах болжээ.



Лондон хот нь тогтвортой хөгжлийг дэмжиж, хотын төвөөр дизель хөдөлгүүртэй автомашиныг бүрэн хориглохоор болсон.



УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ

# ХҮН ТӨВТЭЙ ХОТ

**ЗОРИЛТ 9.1** Иргэдийнхээ хөгжих боломжийг хангасан хөдөлмөрийн үнэлэмж өндөртэй эрүүл чийрэг, бүтээгч, оюунлаг иргэдтэй хот болно.

**ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН**

**I ҮЕ ШАТ | 2021-2030**


Нийгмийн дэд бүтцийн чанар, хүртээмжийг сайжруулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх үе

**II ҮЕ ШАТ | 2031-2040**

Иргэн төвтэй нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж, тэгш байдлыг хангасан, үр ашигтай тогтолцоог бэхжүүлэх үе

**III ҮЕ ШАТ | 2041-2050**

Дэлхийд өрсөлдөх чадвартай, бүтээлч, нийгмийн идэвхтэй иргэд бүхий хотын хөгжлийг дэмжих үе



Хүн төвтэй хөгжлийн бодлого нь ард иргэдийн эрүүл мэнд, ажиллаж амьдрах, сурч боловсрох орчин нөхцөл, хөгжиж дэвших боломж бололцоог тэгш хүртээмжтэй олгоход чиглэнэ. Үүний тулд нийгмийн үйлчилгээ, дэд бүтцийн чанар хүртээмжийг сайжруулж, үр ашигтай болгох замаар дэлхийд өрсөлдөх чадвартай, идэвхтэй, бүтээлч иргэдийг төлөвшүүлнэ.

Дэлхий нийтээр хөгжлийн түвшинг эдийн засгийн өсөлтөөр хэмжихээс илүү хүний хөгжлийг хангахад чиглэсэн бодлогын үр дүнг анхаарах, тав тухтай амьдралын орчин нөхцөлийг бүрдүүлэх, урт хугацаанд тогтвортой хөгжих чиг хандлага давамгайлах болсон. Олон улсад энэ бүгдийг багцалсан ойлголтоо хүний хөгжлийн тулгуурууд хэмээн үзэж, илүү нарийвчлан бодлого зорилтоо чиглүүлдэг. Аливаа хотын хөгжлийг зам, дэд бүтцийн хангамж, өндөр ганган барилга байгууламжаар хэмжих бус хүний хөгжлийн үзүүлэлтээр, тухайлбал боловсрол, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин болон тухайн хотын иргэд амьжиргааны зохистой түвшинд байгаа эсэхээр тодорхойлдог. Иргэд нь хотдоо амьдрах соёлыг нүүдлийн соёлтой хослуулах өвөрмөц шийдлийг олж хэрэгжүүлснээр нийслэл хотоо хэн бүхэнд таатай, найрсаг хот болгож хөгжүүлэхийг зорьж байна.

Эрүүл, аюулгүй орчинд амьдрахаас эхлээд чанартай боловсрол эзэмших, тэгш хүртээмжтэй нийгмийн суурь үйлчилгээг авах, цаашлаад чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, сонирхлоо



хөгжүүлэх, тусгай хэрэгцээгээ хангуулах нь нийгмийн асуудлаас гадна хот төлөвлөлтийн чухал бүрэлдэхүүн хэсэг. Зам тавьж, байшин барихаас эхлэлтэй энэ бүх хэрэгцээг хэрхэн хангаснаар нь тухайн хот иргэндээ ээлтэй эсэхийг хялбархан мэдэж болно.

Улаанбаатар нь сая гаруй хүн ажиллаж амьдардаг дэлхийн метрополитан хотуудын нэг. Сая гаруй хүнд зориулсан нийгмийн дэд бүтцийн чанар хүртээмжийг сайжруулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага үүссэн. Иргэн төвтэй нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж, тэгш байдлыг хангасан үр ашигтай тогтолцоог бэхжүүлснээр дэлхийд өрсөлдөх чадвартай, бүтээлч, нийгмийн идэвхтэй иргэдтэй хотыг бий болгож чадах юм.

### **ХОТЫН ИРГЭДИЙН БОЛОВСРОЛ**

Хотын хүн амын өсөлт шилжин ирэгсэд ба төрсөн иргэдийн тооноос хамаардаг. Хотын боловсролын үйлчилгээ энэхүү динамик өсөлтийг харгалзан төлөвлөгдөх ёстой болдог. Мөн хөгжил, цаг үетэй хөл нийлүүлэн алхах үндсэн шаардлагатай уялдан иргэн бүрд боловсролын үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилтыг хангах нь чухал. Хүний хөгжлийн зорилгын хүрээнд боловсролын талаар баримталж байгаа бодлогод хүн амын өсөлтийг даган бий болсон эрэлтэд үндэслэн сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг хангахаар төлөвлөсөн. Энэ нь хотын боловсролын үйлчилгээний нэг гол хөрөнгө оруулалтын чиглэл болдог. Мөн шинээр шилжин ирж байгаа гэр бүлийн оршин суудаг захын хороо, суурьшилд сургууль, цэцэрлэгийн үйлчилгээг ойртуулах асуудлыг орхигдуулж болохгүй. Өнөөгийн боловсролын

### **Анхдагч хэрэгцээ**

Хотын иргэд эрүүл, аюулгүй орчинд амьдарч, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг хүртээмжтэй хүртэн өөрсдөө хөгжих нөхцөлөөр хангагдах ёстой.



Нийгмийн дэд бүтэц иргэн бүрд тэгш хүртээмжтэй байж, 2050 онд Монгол хүний хөгжлийн үзүүлэлтийг 0.9-д хүргэх юм.



УЛААНБААТАР БА  
ДАГУУЛ ХОТ


**ХҮН ТӨВТЭЙ  
ХОТ**

үйлчилгээний чанарыг дэлхий нийтийн чиг хандлагатай уялдуулан агуулга, хэлбэр, шинэчлэлийг цаг үргэлж хийх ёстой. Нийслэл хотын хэмжээнд сургууль, цэцэрлэгийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, хүүхэд нэг бүрийг сургууль, цэцэрлэгт бүрэн хамруулах тогтолцоог бүрдүүлэх нь ойрын ирээдүйн томоохон сорилт, тэргүүний зорилго байх юм. Сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, засварлах зэргээр суудлын тоог нэмэгдүүлж, бүлэг дүүргэлтийг норматив хэмжээнд хүргэх асуудлыг шийдвэрлэнэ. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн суралцагчийн хэрэгцээ, шаардлагыг хангасан цогц хөгжлийн төв болгон хөгжүүлэх хэрэгцээ улам бүр өсөн нэмэгдэж байна.

Хотын хүн амын нягтралтай холбоотой шинээр бүтээн байгуулах сургууль, цэцэрлэг барих газрын хүрэлцээгүй байдлыг эртнээс төлөвлөх замаар шийдэх арга замыг эрэлхийлнэ. Дэлхий нийтийн жишгийн дагуу хүн амын төвлөрлийг дагасан бага насны хүүхдэд ойр цэцэрлэг, бага сургуулийн бие даасан цогцолборыг төрөлжүүлэн хөгжүүлнэ. Ингэснээр хүүхэд зөвхөн хичээл хийж, ном үздэг газар биш ирээдүйн чиг баримжаагаа бүрэн дүүрэн олж авдаг, цогц хөгжлийн эхлэлийг цэцэрлэг, сургуулиасаа байршил харгалзахгүй авдаг болох юм.

Орчин үеийн техник, технологийн дэвшлээс ч хоцрох ёсгүй. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлж, цахим болон зайн сургалтын

Зураг 5. Улаанбаатар хотын сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн тоо (хэтийн тооцоо)



Эх сурвалж: УСХ, 2021



танхимыг байгуулна. Чанартай боловсролын үйлчилгээг үзүүлэхэд мэргэжлийн өндөр ур чадвартай багш нар хамгаас чухал. Тиймээс хамтын ажиллагаатай улс, хотуудад багш солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Мөн сурагч солилцооны болон тэтгэлэгт хөтөлбөрт хүүхдүүдээ хамруулна.

Сурч боловсрохоос гадна хүүхдэд аюулгүй орчин хамгаас чухал. Хүүхэд харах төв, Хүүхэд хамгаалах төв, тусгай хэрэгцээт хүүхдийн өдөр өнжүүлэх төв, асрамжийн газрын хүчин чадлыг нэмэгдүүлж, шаардлагатай тохижилт үйлчилгээг хийнэ. Нас, хүйснээс үл хамааран хүн бүр сурч боловсрох эрхтэй. Насанд хүрэгчид болон ахмад настнуудад зориулсан сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж, насан туршийн боловсролын үйлчилгээг хэвийн хэв хэмжээ болгон бүх насны иргэдэд зориулсан спортын талбай, танхимын хүртээмжийг нэмэгдүүлнэ.

## ИРГЭН БҮРД ХҮРЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, өвчнийг эрт илрүүлэх, оношлох, эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгийг тогтмолжуулах нь нэн тэргүүний зорилт болж байна. Энэ талаар ахиц өөрчлөлт гарч байгаа ч нийгмийн эрүүл мэндийн боловсрол, орчны бохирдолтой холбоотой өвчлөл, нас баралт Улаанбаатар хотын хэмжээнд буурахгүй байна. Цаашдаа өрхийн болон дүүргийн эрүүл мэндийн төвүүд анхан шатны тусламж үйлчилгээнд дэвшилтэт арга технологийг нэвтрүүлж, түргэвчилсэн оношилгоо болон өдрийн, сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламжийг бэхжүүлэхэд онцгой анхаарч байна. Ингэснээр алслагдсан орон нутгаас гуравдугаар шатлалын эмнэлэгт үзүүлэхээр заавал Улаанбаатар хотыг зорин ирэх шаардлагагүй болж өвчтөнүүд оношилгоо, эмчилгээг цаг алдалгүй орон нутагтаа авах боломж бүрдэх юм. Гуравдугаар шатлалын эмнэлгүүд нийслэл хотод төвлөрсөн байгаа нь эдгээр эмнэлгийн ачааллыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ иргэд эрүүл мэндийн үйлчилгээг яаралтай авч чадахгүйд хүрэх эрсдэлд хүрч байна.

Иймд эрүүл мэндийн салбарын бүтээн байгуулалт, эмч эмнэлгийн ажилтны хүртээмж, өрхийн эмнэлгийн үйлчилгээ, тоног төхөөрөмжийг сайжруулах зорилт тавьсан. Тухайлбал, эрүүл мэндийн байгууллагуудыг шинээр барьж, өргөтгөн шинэчлэн засварлаж, стандартын шаардлага хангасан тохижилт, үйлчилгээний орчныг бий болгоно. Дүүргийн жишиг эрүүл мэндийн төвүүдийн барилгыг шинээр барьж, оношилгоо эмчилгээний чадавхыг сайжруулан ерөнхий мэс засал, дурангийн мэс засал, хавдар, хөнгөвчлөх, сэргээн засах тусламж үйлчилгээг үе шаттай хөгжүүлнэ. Алслагдсан дүүрэг, дагуул хотуудад телемедицин, цахим эрүүл мэндийн

### *Хүн төвтэй хотын төлөвлөлт*

Хотын хүн амын амьдралын чанарт эрс өөрчлөлт бий болгох шийдэл нь хүн амын төвлөрлийг багасгах төлөвлөлт юм. Хотын төвөөс 25 км радиус, 100 км радиустай тойрог дагуу хөгжлийн төлөвлөлтийг хийж, хотын гарцуудыг төрөлжүүлэх, хотын дэд төвүүдийг байгуулах ажлыг дагуул, хаяа хотуудын хамт төлөвлөсөн.

Иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамруулж хэвшүүлэх, ийм тогтолцоог бэхжүүлэх нь нийгмийн эрүүл мэндийн хүрээнд хийх томоохон зорилт юм.

УЛААНБААТАР БА  
ДАГУУЛ ХОТ

## ХҮН ТӨВТЭЙ ХОТ

Амьдрахад таатай хотуудын гол үзүүлэлтэд боловсролын хүртээмж, эрүүл мэндийн үйлчилгээ авах боломж, хүнсний эрүүл ахуй, ажлын байр, авто замын чанар зэрэг 30 гаруй хүчин зүйл багтдаг.

дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ. Эрүүл мэндийн урт хугацааны тусламж, үйлчилгээний загварыг гаргаж, сэргээн засах, хөнгөвчлөх, сувилахуйн төвийг байгуулж, энэ чиглэлд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын оролцоог хангана.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бааз суурийг ингэж чадавхжуулан бэхжүүлэхээс гадна нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулж, Улаанбаатар хотын иргэн нэг бүрийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх ажлыг шинэ шатанд гаргахаар төлөвлөв. Ерөнхийдөө эрүүл мэндийн үйлчилгээг өдрийн эмчилгээ, өрхийн эмнэлгийн үйл ажиллагаанаас эхлэн өргөжүүлэн тэлж, чадавхжуулах замаар эмнэлгийн тусламж үйлчилгээний нэгдсэн зохицуулалттай, бүсчилсэн сүлжээг байгуулж, тогтвортой үйл ажиллагааг хангах юм.

### ТААТАЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ ОРЧИН

Хүүхдээс эхлээд өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүн бүхэнд ээлтэй орчныг хэрхэн бүрдүүлснээр нь Хүн төвтэй хотын хөгжлийг тодорхойлно.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хэн нэгний тусламжийг авахгүйгээр сурч боловсрох, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах, найз нөхөдтэйгөө уулзах, агаар салхинд гарах боломжийг бүрдүүлэхийн тулд эхний ээлжид байгууллагуудын нийгмийн хариуцлагыг дээшлүүлнэ. Ийм замаар хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлэх орчныг бүрэн хангана. Шинээр баригдах барилга бүр тэдэнд зориулсан зам, шаттай байхаас эхлээд ариун цэврийн өрөө нь ч тусгай хэрэгцээт хүмүүсийн шаардлагыг хангасан байх ёстой. Хөгжлийн бэрхшээл хүнээс биш нийгмээс үүсээд буйг засах нь бидний зорилго байх юм.

Ахмадуудад зориулсан хөгжлийн төв, хөдөлмөр эрхлэх боломж хомс. Тиймээс тэдэнд зориулсан хөгжлийн төв байгуулж, асрамжийн газрын хүчин чадлыг нэмэгдүүлж, шаардлагатай тохижилтыг хийж, үйлчилгээг сайжруулна. Туршлага хэзээ ч хөгширдөггүйн жишгээр ахмадууд ажил, амьдралын арвин туршлагатай нийгмийн чухал хэсэг гэдгийг харуулах бодлого баримтална.

Харин залуучуудад амрах, чөлөөт цагаа зөв өнгөрөөх, спортоор хичээллэх орчин шаардлагатай. Тэдний энэ шаардлагыг хангахын тулд хотын хэмжээнд спортын зориулалтын талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, биеийн тамир, спортын барилга байгууламжийг төлөвлөн байгуулна. Өөрөөр хэлбэл хотын өнцөг булан бүрд залуучууд хүссэн газраа дуртай спортоороо хичээллэх боломж бүрдүүлэхийг зорьж байна.

Улаанбаатар залуучуудын хот. Тэр хэрээр манай хот хурдтай хөгжилтэй, хүчтэй өрсөлдөх чадвартай, хүнээ дээдэлсэн эрүүл



нийгэмтэй байх ёстой. Бидний нийслэл үеэ өнгөрөөж буй хөгшин буурал хот биш цэцэглэн хөгжих боломжтой залуухан Улаанбаатар.


Нийслэлд жил ирэх тусам орон нутгаас шилжин ирэгсдийн тоо нэмэгдэж байгаа нь анхаарлын төвд байх бас нэг асуудал. Тэдний багагүй хувь нь амьжиргааны түвшнээс доогуур орлоготой учир нийтийн тээвэр, боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн суурь үйлчилгээнд бүрэн хамрагдаж чадахгүй эрсдэлд байна. Энэ нь улмаар зөвхөн тухайн иргэд бус хотын хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдал, эдийн засагт сөргөөр нөлөөлдөг. Иймд иргэдийг ажил орлоготой болгох, гэр хорооллыг дахин төлөвлөж инженерийн шугам сүлжээ татах зэрэг ажлыг төлөвлөөд байна.

Орчин үеийн хот нь хүн амьдрахад таатай, бүхий л хэрэгцээгээ хангах нөөц, боломж бүрдсэн хүн төвтэй үзэл санаа дэлхий даяар хандлага, нийтлэг жишиг болж байна. Тиймээс манай улсын хувьд ч энэ чиглэлд хөгжихийг төрийн урт хугацааны бодлогынхоо нэг хэсэг болголоо. Хотын нийт иргэдийн боловсролын түвшин өндөр, эрүүл саруул, таатай орчинд амьдран суух бололцоог бүрдүүлсэн хотыг хамтдаа бүтээн байгуулах болно.

### Чиг хандлага

Метрополитан хотын иргэд унадаг дугуй түлхүү хэрэглэдэг нь дугуйнд зориулсан замыг сайтар хөгжүүлж өгсөнтэй холбоотой байдаг.

Зураг 6. Улаанбаатар хотын унадаг дугуйн замын сүлжээ



Эх сурвалж: НЗДТГ, 2021

## ХҮНД ЭЭЛТЭЙ ХОТ

Хотын иргэдэд чиглэсэн нийгмийн бүх салбарын хөгжлийн нэг бодит хэмжүүр нь хүн амын зорилтот бүлэгт үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийн үзүүлэлт юм. Хүүхэд хамгаалах төв, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөр өнжүүлэх төв, асрамжийн газрын хүчин чадлыг нэмэгдүүлж, зорилтот бүлгийн хүн амын тэгш боломжийг хангах бодлогыг хэрэгжүүлнэ. Боловсрол, эрүүл мэндийн болон иргэдийн тав тухтай амьдралын орчин бүрдүүлэхдээ энэхүү бодлогыг харгалзсан стандарт, дүрмийг заавал мөрдөхийг жишиг болгоно.



### Ээлтэй үйлчилгээ, хүртээмж

Улаанбаатар хотод хэн бүхэн аливаа үйлчилгээг хүртээмжтэй, ялгаварлалгүй хүртэх эрхтэй.



## ЗАЛУУЧУУДЫН ХОТ



Улаанбаатар хотын хүн амын 60 гаруй хувь нь залуучууд байна. Залуучууд зөв, хөдөлмөрч, боловсролтой, хотоо гэсэн сэтгэлтэй байвал хотын өнгө үзэмж сайжирч, өргөжин тэлнэ. Нөгөө талаас хотын зүгээс залуучуудад ээлтэй бодлого хэрэгжүүлж, тэднийг хөдөлмөр эрхлэлт, өөрийн сонирхлоор нь дэмжих нөхцөлийг бодитоор бий болгоход чиглэх учиртай. Залуучуудад зориулсан үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн, хөдөлмөрлөх боломжийг нээж, орчин нөхцөлөөр нь хангаж өгснөөр өөрсдийн сонирхож байгаа зүйлээ хийж, түүгээрээ орлого олдог залуучуудын хотыг хамтдаа бүтээнэ.



### Хамтдаа хөгжих орчин

Залуучуудад зориулсан үйлчилгээний төрөл, салбарыг нэмэгдүүлэн хүртээмжийг тэлж, тэднээс гарсан санал санаачилгыг дэмжиж, хамтдаа амьдрах орчин бидний хот гэсэн сэтгэлгээг төлөвшүүлнэ.

УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ

# ОРЧИН ТӨВТЭЙ ШИЙДЭЛ

**ЗОРИЛТ 9.2** Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи бүхий амьдралын таатай орчинтой хот болно.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

**I ҮЕ ШАТ | 2021-2030**


Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангаж, нөхөн сэргээх, хариуцлагатай, хэмнэлттэй хэрэглээг бий болгох үе

**II ҮЕ ШАТ | 2031-2040**

Хотын экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан ногоон, ухаалаг технологийн үе

**III ҮЕ ШАТ | 2041-2050**

Хүлэмжийн хийн ялгарал багатай, байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах үе



Орчин төвтэй шийдэл гэдэг олон улсын жишиг, дэлхийн хотуудын чиг хандлагад нийцүүлэн хотын стандартыг батлан хэрэгжүүлж, иргэдийн ажиллаж амьдрах аюулгүй, эрүүл орчин нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрийг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай, ногоон технологи бүхий хотын хөгжлийг дэмжих зорилт юм.

Дэлхийн стандартаар хотын нэг иргэнд 9 м<sup>2</sup> хэмжээтэй ногоон байгууламж ногдож байх ёстой. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба 2025 он гэхэд нэг хүнд ногдох ногоон байгууламжийг 8 м<sup>2</sup>-д хүргэх зорилтыг дэвшүүлээд байна. Энэ бол иргэдийн амьдралын таатай орчны нэгээхэн хэсэг. Улаанбаатар хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх тодорхой зорилтын нэг нь хотын ногоон байгууламжийн стандарт хэрэгжүүлэх явдал юм. Мод тарихдаа тодорхой стандартын дагуу хаана, ямар мод тарихыг тодорхойлж, хэрэгжүүлнэ. Улмаар хотын ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнгийн талбайг боломжит бүх байршилд нэмэгдүүлж, хот доторх оршуулгын газрыг дахин зохион байгуулна. Хотын уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ойн экосистемийг бий болгож, ой хамгааллын болон нөхөн сэргээлтийн тогтвортой менежментийг шинжлэх ухаан, технологийн шинэ ололтуудад тулгуурлан хэрэгжүүлнэ. Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэхийн тулд мод үржүүлгийн газраа дэмжих ёстой. Мод үржүүлгийн газрын үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэж, ногоон байгууламжид ашиглах



суулгацын чанарыг дээшлүүлж, ашигт ургамлын төрөл зүйлийг нэмэгдүүлэх зорилтыг тавьж байна.

Цаашид Хотын экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан ногоон, ухаалаг технологийг дэмжинэ. Агаар, хөрсний бохирдлыг шат дараатай бууруулах дараагийн нэг томоохон алхам бол орчин үеийн байгальд ээлтэй технологийг нутагшуулах, өдөр тутмын амьдралын хэв маягт нэвтрүүлэх юм. Улаанбаатар хотын нийтийн тээврийн төрлийг нэмэгдүүлэх, агаарын бохирдол үүсгэдэггүй эх үүсвэр ашиглах (цахилгаан болон нарны эрчим хүч г.м) асуудлыг шийдвэрлэнэ. Гудамж талбайн гэрэлтүүлэг, ногоон байгууламжийн усалгаа, ард иргэдийн хэрэглээг ч энэ зүг чиглүүлэх юм.

Мөн хот суурин газрын экосистемийн үнэ цэн, экологийн даацыг тогтоох, уур амьсгалын өөрчлөлтийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх, гамшгийн эрсдэлийг бууруулах менежментийн цогц тогтолцоог боловсронгуй болгон хөгжүүлж, ногоон бүсийн экологийн коридоруудыг байгуулахаар зорьж байна. Улаанбаатар хотын суурьшлын бүсийн хилийг дагуулан суурьшлыг хязгаарлах ногоон бүсийг байгуулахаар төлөвлөлөө.

2025 он гэхэд нэг хүнд ногдох ногоон байгууламжийг



8 м<sup>2</sup>-д хүргэхийг зорьж байна



УЛААНБААТАР БА  
ДАГУУЛ ХОТ

**ОРЧИН  
ТӨВТЭЙ  
ШИЙДЭЛ**

Нөгөө талаар гэр хорооллын нүхэн жорлон, хог хаягдлын асуудлыг шийдвэрлэх замаар хөрсний бохирдлыг бууруулахад чиглэсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Улаанбаатар хот 2050 он гэхэд АМЬДРАЛЫН ТААТАЙ ОРЧИН буюу “Хүлэмжийн хийн ялгарал багатай, байгаль орчны тэнцвэрт байдлыг хангасан хот” болох зорилтыг дэвшүүлсэн. Тээврийн хэрэгслээс ялгарч байгаа хорт бодисын хэмжээг бууруулж, гэр хороололд агаарын бохирдол ихтэй бүсийг орон сууцжуулах ажлыг шат дараатай, системтэй хэрэгжүүлж, агаарын бохирдлыг бууруулна. Ингэж Улаанбаатар хотын эрүүл аюулгүй, байгальд ээлтэй байх зорилтуудыг шат дараалан хэрэгжүүлснээр эцсийн дүнд хот тойрсон байгаль байх бус байгаль дунд орших нийслэл болон тогтнох зорилгод хүрнэ.

### ХАЯГДЛАА БОЛОВСРУУЛДАГ ХОТ

Улаанбаатарчуудын гаргаж буй хог хаягдлыг Морингийн болон Цагаан даваа, Нарангийн энгэр гэсэн гурван цэгт төвлөрүүлдэг. Манай хотод хог хаягдал боловсруулах 36 үйлдвэр байгаа

Зураг 7. Хог хаягдлын хэмжээ, бүтцээр

2020 он



**88.8%**

Дарж булах



**11.2%**

Дахин боловсруулах



**0%**

Хог шатаах

2040 он



**24.6%**

Дарж булах



**50%**

Дахин боловсруулах



**25.4%**

Хог шатаах



Хог хаягдал булах хуучин технологийг халж, дахивар нөөцийг дахин боловсруулалтад оруулдаг олон улсын туршлагыг Улаанбаатар хотод хэрэгжүүлнэ.



Эх сурвалж: НЗДТГ, 2021



ч хангалттай ажилладаггүй. Тиймдээ ч нийт хог хаягдлынхаа 90 хувийг булдаг. Харин одоо хог хаягдлыг булдаг хуучин технологиос татгалзах цаг ирсэн. Урьдчилсан тооцоогоор Улаанбаатар хот 2040 он гэхэд нийт хог хаягдлын 50 хувь буюу дахивар нөөцийг дахин боловсруулж, дахин боловсруулалтад оруулах боломжгүй 42 хувийг шатааж устган эрчим хүч гаргаж, төвлөрсөн хогийн цэгийн ландфилд дарж булшлах, хог хаягдлын хэмжээг бууруулах зорилт тавин ажиллаж байна.

Урт хугацаанд хог хаягдлын тогтолцоо бүрдүүлнэ. Хог хаягдлыг ангилан ачих, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд технологийн шинэчлэлийг нэвтрүүлж, бохирдол бага ялгаруулах, хог хаягдалгүй хэрэглээг дэмжих тогтолцоотой болно. Мөн дахивар, түүхий эдийн дахин боловсруулах жижиг, дунд үйлдвэрүүдийг байгуулж, төрөлжүүлэн хөгжүүлнэ. Тухайн үйлдвэрүүд нь ахуйн болон цахилгаан станцуудаас гарах үнс, лаг, хог хаягдлыг дахин ашиглаж, хоёрдогч бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Ингэснээр Нарангийн энгэр, Цагаан давааны төвлөрсөн цэгийн ландфилийн талбайг бүрэн хааж, нөхөн сэргээх боломж бүрдэх юм.

#### **ДАХИВАР**

Хог хаягдлыг дахин боловсруулдаг 40 гаруй үйлдвэр, ялган бэлтгэдэг 160 гаруй цэг Улаанбаатар хотод ажиллаж байна.


УЛААНБААТАР БА  
ДАГУУЛ ХОТ

ОРЧИН  
ТӨВТЭЙ  
ШИЙДЭЛ

Аюултай хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, саармагжуулах, устгах тогтолцоог бий болгоно. Айл өрхүүдийн стандартын бус ариун цэврийн байгууламжийг шинэчилнэ.

Орчны эрүүл байдлыг нэмэгдүүлэх эдгээр арга хэмжээ нь зөвхөн байгаль экологи талаасаа ч биш нийт оршин суугчдын эрүүл саруул аж төрөх асуудалд ч шууд хамааралтай билээ. Тиймээс нэн тэргүүнд “Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангаж, нөхөн сэргээх, хариуцлагатай, хэмнэлттэй хэрэглээг бий болгох” зорилт тавьсан юм.

Зураг 8. Улаанбаатар хотын голын ай сав дагуух ногоон байгууламж





## УСНЫ НӨӨЦӨӨ ХАМГААЛСАН ХОТ

Нийслэлийн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, тэжээгдлийн мужид газар олголт хийснийг технологийн шийдлээр залруулах, газрын доорх усны нөөцийн бохирдлыг цэвэрлэх нэн шаардлагатай байна. Эдгээр шийдлийг хэрэгжүүлж, шинэчлэх замаар нийслэлийн хүн амын ундны усны хангамжийн эх үүсвэрийн аюулгүй байдлыг хангах нь нэн чухал байна.

Усны нөөц, ундны усны баталгаат эх үүсвэрээр хангаж, гадаргын усыг хуримтлуулан, дахин ашиглаж, усны үнэ цэнийг нэмэгдүүлнэ. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийг тусгай хамгаалалтад авч, дэглэмийг чанд мөрдүүлнэ.

**Гол дагасан цэцэрлэгт хүрээлэн** - Улаанбаатар хотын 5 голын эрэг дагуу 75 байршилд модлог болон бутлаг ургамлуудыг иргэдийн амралт, чөлөөт цагаа өнгөрөөх нийтийн хэрэгцээний ногоон байгууламж болгон төлөвлөв.



Голын ай сав дагуух ногоон байгууламжийн байршлын тоо

Туул гол	<b>26</b>
Сэлбэ, Дунд гол	<b>28</b>
Толгойтын гол	<b>11</b>
Тахилтын гол	<b>3</b>
Улиастайн гол	<b>7</b>
Нийт	<b>75</b>



Голын ай сав дагуух ногоон байгууламжийн тохижуулах талбар, га

Туул гол	<b>183,57</b>
Сэлбэ, Дунд гол	<b>135,03</b>
Толгойтын гол	<b>109,72</b>
Тахилтын гол	<b>247,72</b>
Улиастайн гол	<b>1,176.68</b>
Нийт	<b>1,852.2</b>

### Усны нөөц

Гол дагасан цэцэрлэгт хүрээлэнгүүд байгуулснаар ундны усыг тогтоон барих бас нэг чухал алхам юм. Учир нь мод, бутлаг ургамлууд үндсэндээ их хэмжээний ус хадгалж хуримтлуулдаг.

УЛААНБААТАР БА  
ДАГУУЛ ХОТ

## ОРЧИН ТӨВТЭЙ ШИЙДЭЛ

Усны нөөцийг хуримтлуулах, зохистой ашиглах тогтвортой менежментийг хэрэгжүүлэх замаар амьдралыг тэтгэгч чандмань эрдэнийг хайрлан хамгаална.

Ундны усны нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр “Туул усан цогцолбор” төслийн техник, эдийн засгийн үндэслэл, ажлын зураг төслийг боловсруулж, ашиглалтад оруулна. Усан хангамжийн эх үүсвэр, усан сан, гүний худаг, насос станцын аюулгүй байдлыг хангах нэгдсэн хяналтын төвийг байгуулж, теле хяналт, холбоо дохиоллын техник хэрэгслээр тоноглож, дамжуулах түгээх шугамыг салгах төсөл хэрэгжүүлнэ.

Усыг дахин ашиглах, хэмнэлттэй хэрэглэх тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр боломжит бүх байршилд гадаргын ус хуримтлуулах хөв цөөрөм, усан сан байгуулна. Гол эх, намаг бүхий газруудыг орон нутгийн тусгай хамгаалалтад авч, барилга барихаас сэргийлэн ус шингээх чадварыг нь хэвээр хадгалах замаар үерийн эрсдэлийг бууруулна. Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэр, ус цэвэршүүлэх үйлдвэр, цэвэрлэх байгууламжаас гарсан хаягдал усыг дахин цэвэршүүлнэ. Гүний цэвэр усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хязгаарлаж, саарал усны хэрэглээг нэмэгдүүлнэ. Хаягдал лаг, тунадсыг боловсруулан эцсийн бүтээгдэхүүн болгох, цэвэрлэгдсэн усыг боловсруулж, дахин ашиглах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, эргүүлэн ашиглах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хот бол байшин барьж, зам тавихын нэр биш. Усан хангамж зэрэг анхан шатны хэрэгцээг тогтвортой хангасан иргэдийн амьдрах орчин хамгаас чухал. Тиймээс төлөвлөгөө хэрэгтэй. Төлөвлөгөөний дагуу хаана байшин барилга баригдах, ямар хэмжээний ногоон байгууламжтай байх, ус дулаанаа хаанахын дэд бүтцээс хангах, хог хаягдлаа хэрхэн төвлөрүүлж зөөвөрлөх, иргэдийн амарч зугаалах орчныг хэрхэн бүрдүүлэх, хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах гээд цогц асуудлын шийдэл чухал. Тиймдээ ч урт хугацааны бодлогодоо иргэдийн амьдрах орчныг чухалчлав. Энэ нь зөвхөн нийслэлд ногоон байгууламж нэмэгдүүлж, хотын байгалийг хамгаалах асуудал биш. Нэг талаар иргэдийн амьдралын таатай орчин бүрдэх ч нөгөө талаараа эх дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, амар тайван байдалд оруулж буй асар их хувь нэмэр.

Сая гаруй хүн оршин суудаг, цаашид ч иргэд нь өсөн нэмэгдэх хандлагатай нийслэл хот өнөөгийн өнгө төрхөөр удаан явахгүй. Хүн ам нэмэгдэхийн хэрээр бидэнд асуудал олширч, шийдлээ хүлээсээр байх болно. Тиймээс асуудлыг урт хугацаанд харж, шийдвэрлэх арга замыг тодорхойлсон юм.

Эсгий гэрээ ачаалан нүүдэллэж байсан монголчууд байшин барилга барьж сурсан. Шилэн өндрүүдийг ч сүндэрлүүлж чадаж байна. Харин одоо цогц төлөвлөлттэй орчин бүрдүүлэх цаг ирж,



энэ чиглэлд илүү анхаарах шаардлагатайг бидний өдөр тутмын ажил, амьдралын алхам бүр сануулсаар байна. Иргэдийн чиг хандлага ч өөрчлөгдөж байна. Үл хөдлөх хөрөнгө худалдан авахдаа тухайн байршлын ногоон орчин, цэвэр усан хангамжийг илүү тооцдог болжээ. Өөрөөр хэлбэл хэдий чинээ таатай орчин бүрдүүлсэн байна, төдий чинээ үнэ цэнд хүрч буйг үл хөдлөх хөрөнгийн зах зээл ч харуулсаар байна. Ийм орчин нөхцөлийг бүрдүүлж чадвал иргэдийн хөрөнгийн үнэ цэн нэмэгдэж, орлого өсөх, эрүүл амьдралын эх сурвалж болох үндэс суурь тавигдана. Мөн үүнийг амьдралын чанар дээшилснийг илэрхийлэх үзүүлэлт болгон харж болно.

#### **УСНЫ ЭХ ҮҮСВЭР**

Туул гол бол нийслэлчүүдийн ундны усны эх юм. Тиймээс Туул голын эх, ай сав газрыг хамгаалах нь байгалиа хамгаалах төдийгүй хотын иргэдийн эрүүл, аюулгүй амьдралын төлөө хийж буй чухал алхам юм.

## ЭКО ХОТ



Хотын хөгжлийн бодлогыг байгалийн нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай хэрэглэж, экосистемийн үйлчилгээг тэтгэсэн, хүлэмжийн хийн ялгарал, хаягдал багатай, ногоон хөгжлийн загварт тулгуурлан “эрчим хүч, дулаан, ус хангамж, харилцаа холбоо, нийтийн тээврийн ухаалаг дэд бүтэц, хог хаягдлын оновчтой менежмент бүхий хүний амьдралын тав тух, хөгжлийн боломжийг хангасан ногоон хот” болохыг зорьж байна. Хотод баригдах барилга, хороолол бүр хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй, материал ашигласан, дулааны алдагдал хамгийн бага байх хийцтэй, агаарт ялгаруулах хор багатай халаалтын шийдэлтэй, эрчим хүч, нөөцийн хэмнэлт, үр ашигтай, хур тунадасны усыг хуримтлуулж ашиглах, хаягдал бохир усаа цэвэрлэж зайлуулах технологи бүхий, тав тухтай орчныг бүрдүүлэхэд чиглсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.



### Шинэ жишиг, шаардлага

Эко хотын үзэл баримтлал амьдрах орчныг байгаль орчинд ээлтэй, хэмнэлттэй, хог хаягдалгүй бүтээн байгуулах шинэ шаардлага төдийгүй барилга байшин, зам, дэд бүтцийн байгууламжууд хүн бүхэнд ээлтэй байдлаар бүтээгдэх ёстой жишгийг баримтлах болно.



## ХАЯГДАЛГҮЙ ХОТ



Дэлхийн олон хотын тэргүүн туршлага болсон хог хаягдлыг эх үүсвэрээс нь буюу хаалганаас-хаалганд цуглуулдаг аргыг нэвтрүүлэх, ангилах, тээвэрлэх үйлчилгээнд шинэ технологийн дэвшлийг хэрэглэх, дахин ашиглах боломжтой дахиврыг тусад нь цуглуулах, дахивар хаягдлыг хогийн цэгт буулгахаас өмнө эх үүсвэр дээр нь ялган ангилах зорилтыг хэрэгжүүлж, хаягдалгүй хот болно. Үүнийг хэрэгжүүлэхэд зөвхөн хороо, дүүргийн удирдлага төдийгүй оршин суугчид, албан байгууллагууд ч чухал үүрэгтэй. Солонгос, Япон, Швед зэрэг хог хаягдлаа эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, дахин боловсруулдаг олон жилийн туршлагатай орнуудын жишгээр үр дүнд хүрэх боломжтой. Цаашид өрх гэр бүл, хороо дүүрэг, аж ахуйн нэгж гэсэн гурван түвшинд хог хаягдлыг бууруулах, ангилах менежментийг хэрэгжүүлнэ.



### Цэмцгэр хот

Дэлхий нийтээр хотын хог хаягдлын менежментийн шинэ арга туршлагыг нэвтрүүлж байна. Гэр бүл, айл өрх, хороо, дүүрэг, хот бүхэлдээ цэвэр цэмцгэр байхыг эрхэмлэж, хүн бүр өдөр тутмын амьдралын хэм хэмжээ болговоос цэмцгэр хотдоо хамтдаа аж төрөх билээ.

УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ

# ТӨЛӨВЛӨЛТ ТӨВТЭЙ ХӨГЖИЛ

**ЗОРИЛТ 9.3** Орон зайн оновчтой төлөвлөлт бүхий суурьшлын зөв тогтолцоотой, эрчимтэй хөгжиж байгаа дагуул хотуудтай олон улсад өрсөлдөгч метрополитан болж хөгжинө.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

**I ҮЕ ШАТ | 2021-2030**


Хотын төвлөрлийг задалж, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ухаалаг технологийн шинэчлэлийн үе

**II ҮЕ ШАТ | 2031-2040**

Дэд бүтцийн бүрэн хангамжтай, ухаалаг систем бүхий хотын хөгжлийг эрчимжүүлэх үе

**III ҮЕ ШАТ | 2041-2050**

Амьдралын таатай орчин бүрдсэн метрополитан хөгжлийн үе



Хүн эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол үүсэх, байгалийн тэнцэл алдагдахаас сэргийлж, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрхийг хангаж, хотын төлөвлөлтөө хийх нь хөгжлийн үндэс юм. Хот суурин газрын хөгжлийн төлөвлөлтийг хамрах хүрээнээс нь хамааран ерөнхий болон хэсэгчилсэн байдлаар боловсруулдаг.

**ГАЗАР ДООРХ ХОТ**

Анх 500 орчим мянган хүнтэй байхаар төлөвлөн байгуулсан Улаанбаатар хотод өдгөө улсын нийт хүн амын 47.6 хувь нь амьдарч байна. Улаанбаатар хотод суурьшсан иргэдийг гэнэтийн гамшигт өртөхөөс сэргийлж, дэд бүтцийг төлөвлөх учиртай. Зөвхөн гамшгаас сэргийлэх бус цаашид хөгжил дэвшил, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэхэд дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай юм. Хотын иргэдийн тав тухтай амьдралын эх үүсвэр, эд хөрөнгийнх нь бүрэн бүтэн байдлын баталгаа нь “газар доорх хот” буюу дэд бүтцийн шийдэл билээ. Улаанбаатар хотын төвлөрөл, суурьшсан нутаг дэвсгэрийн тэлэлт, хязгаарлалт, газар зохион байгуулалт, авто замын сүлжээ, нийтийн тээвэр, газар доорх орон зай гэх мэт шаардлагатай төлөвлөлтийг тооцон хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, мэдээллийн нэгдсэн системд холбон хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Ингэхдээ инженерийн дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлж, технологийн шинэ шийдэл нэвтрүүлж нутагшуулна. Газар доорх



Зураг 9. Хот төлөвлөлтийн зарчим

**НОГООН БҮС**

Ойн сан, түүний 100 метрийн хамгаалалтын бүс, усан сан, энгийн болон онцгой хамгаалалтын бүс, тусгай хамгаалалт бүхий нутаг дэвсгэрийг тогтоох



**ЦЭНХЭР ДЭД БҮТЭЦ**

Голуудын тогтмол урсац бүхий сүлжээг сэргээж, гадаргын болон газрын доорх усны нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор хамгаалалтын бүс, цөөрөм, усан санг төлөвлөх



**ХОТЖИХ НУТАГ ДЭВСГЭР**

Нийслэлийн нутаг дэвсгэрт дагуул хот, тосгодыг тодорхой хилийн цэсийн хүрээнд хотжилтыг дэмжиж хөгжүүлэх



**НОГООН ДЭД БҮТЭЦ**

Нийслэлийн нутаг дэвсгэрийн нийт 116,257 га ойн сангийн талбайг нэмэгдүүлэх зорилгоор ой тэлэн ургах боломжит 9 ойн массивын хил хязгаар тогтоох



**ЭКОЛОГИЙН КОРИДОР**

Ногоон бүсүүдийг холбосон 1км-ээс багагүй өргөнтэй, зэрлэг ан амьтад нутаг сэлгэж, нүүн шилжих боломжтой байх



**ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТАГ**

Тусгай хамгаалалттай газар нутагт үүссэн суурьшлын бүсэд газар ашиглалтын горим дэглэмийг тогтоосон, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах



Эх сурвалж: НЗДТГ, 2021

орон зайг оновчтой ашиглаж, зам тээвэр, инженерийн шугам сүлжээнд ашиглана. Мөн хотын аюулгүй байдлыг хангасан дохиолол, хяналт удирдлагын бүрэн автомат нэгдсэн системийг бий болгоно. Хот дахин төлөвлөлтийн хүрээнд гэр хорооллыг төвлөрсөн, хэсэгчилсэн болон бие даасан инженерийн хангамжид холбон, сэргээгдэх эрчим хүчийг ашиглах юм. Товчхондоо дэлхийн хотуудын жишгээр газар доорх хотыг байгуулах зайлшгүй шаардлагатай.

Жилийн дөрвөн улиралтай манай улсын нийслэл Улаанбаатар бол дэлхийн хамгийн хүйтэн 10 хотын нэг. Хотод маань дулаан, цахилгаан хангамжийн асуудал юу юунаас илүү чухал. Тиймээс хотын иргэдийг ая тухтай аж төрөх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлд эрчим хүчний хэмнэлтийн бодлого хэрэгжүүлж, нийслэлийн алслагдсан бүсүүдэд байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи бүхий бие даасан дулааны эх үүсвэрүүдийг барьж байгуулан, төвлөрсөн дулаан хангамжийн системд холбож, оргил ачааллын үед ажиллах хэсэгчилсэн байдлаар шийдвэрлэн үр ашгийг нь дээшлүүлнэ.

*Нэгжийн хөгжил*

Хот төлөвлөлт бүхнийг багтаасан цогц хөтөлбөр боловч түүнийг бүрдүүлэгч нэгж бүрийн бие даасан байдлыг хэрхэн хангаж байгаагаас хэрэгжилт хамаарна.

УЛААНБААТАР БА  
ДАГУУЛ ХОТ


**ТӨЛӨВЛӨЛТ  
ТӨВТЭЙ  
ХӨГЖИЛ**

### ОРОН СУУЦНЫ БОДЛОГО

Хүний эрүүл энх, тав тухтай амьдрах үндсэн нөхцөлийн нэг нь орон байр, тохилог сууц юм. Монгол Улсын төр засгаас сүүлийн жилүүдэд хүний хөгжлийг хангах, амьдралын чанарыг сайжруулах зорилгоор орон сууцны хүрэлцээ, хангамжийг нэмэгдүүлэх, нөхцөлийг сайжруулахад чиглэсэн эдийн засаг, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд тодорхой арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Орон сууцны чанар, хүртээмж нь улсын хөгжил, нийгмийн амьдралын түвшнийг тодорхойлох гол үзүүлэлт, хүн амын эрүүл амьдрах нөхцөл болохын хувьд Монгол улсын төрийн бодлогын салшгүй хэсэг юм. Хот суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан иргэдийг орон сууцжуулах, инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх, төвлөрсөн болон бие даасан ус хангамж, ариутгах татуурга, ариун цэврийн байгууламж, цэвэрлэх байгууламж, нийтийн халуун ус, дулаан, цахилгааны шугам сүлжээний ашиглалт, үйлчилгээтэй холбогдсон техник, технологийн нэгдсэн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх, удирдлага, зохион байгуулалт, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хөрөнгө оруулалт хийх, хяналт тавих үйл ажиллагааны хүрээг хамарсан цогц асуудал билээ.

Зураг 10. Орон сууцны хангамж, төлөвлөлт



Эх сурвалж: Монгол Улсын Засгийн газар, 2021



Олон төрлийн орлогод нийцсэн түрээсийн, ногоон гэр хорооллыг дахин төлөвлөх зэрэг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх замаар орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх юм. “Орон сууцны тухай” хуулийн 8.1.1-д “нутаг дэвсгэртээ орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах болон хүн амын эмзэг хэсгийг орон сууцаар хангах бодлого тодорхойлж, хэрэгжилтэд нь хяналт тавих” ажлыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхэд, 8.2.2-т “орон сууцны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах”, 8.2.4-т “орон сууц хөгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэх” асуудлыг Нийслэлийн Засаг даргын бүрэн эрхээр хэрэгжүүлэхээр тус тус заасан байдаг.

Улаанбаатар хотын хэмжээнд бүтээн байгуулалтыг өрнүүлж, гэр хорооллыг дахин төлөвлөн орон сууцны хороолол болгон хөгжүүлж, орон сууцны хангамжийг төвлөрсөн шугам сүлжээнд 70 хувь, инженерийн бие даасан эх үүсвэрт 30 хувийг холбоно. Эхний шатанд гэр хорооллын дахин төлөвлөлтөөр 45,000 айл, газар шинэчлэн зохион байгуулах төслөөр 13,500 айл, ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг буулган дахин барилгажуулах төслөөр 7,746 айл, орлогод нийцсэн орон сууцны төслөөр 38,826 айл, дагуул хаяа хот, тосгод хөгжүүлэх төслөөр 16,512 айлын орон сууцны барилга ашиглалтад оруулахаар төлөвлөсөн. Нийслэлийн бага, дунд орлоготой болон зорилтот бүлгийн иргэдэд зориулсан орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, иргэд сууцны нөхцөлөө сайжруулан инженерийн бүрэн хангамжтай орон сууцтай болох нөхцөлийг бүрдүүлнэ. Нийслэлээс иргэдийг орон сууцжуулах талаар баримталж буй бодлого, хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээ нь хөрөнгө оруулалт, дэд бүтцийн төлөвлөлтийн уялдаа холбоог сайжруулахад чиглэж байна.

Ингэснээр нийслэлд хүн ам, нийгэм, эдийн засгийн хэт төвлөрөлт, хотжилттой холбогдон үүсэж буй сөрөг үр дагавруудыг багасгах, нийслэлийн гэр хорооллын орчныг сайжруулах, гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулах, дахин төлөвлөн барилгажуулах, шинэ суурьшлын бүсийг бий болгох, хуучин орон сууцнуудыг шинэчлэн барилгажуулах замаар нийслэлийн иргэдийг эрүүл, аюулгүй орчин, стандартын шаардлага хангасан орон сууцанд амьдах нөхцөлийг бүрдүүлэх, нийслэлийн зорилтот бүлгийн иргэдийг хямд, чанартай орон сууцаар хангахыг зорьж байна. Цаашид дээрх төсөл, арга хэмжээнүүд урт хугацаандаа, цогц байдлаар, харилцан уялдаатай, шат дараалан хэрэгжсэнээр орон сууцны хангамж зорилтот түвшинд хүрч, тохилог, тав тухтай, амьдрахад таатай нөхцөл бүхий чанартай орон байраар айл өрх бүр хангагдах болно.

Орон сууцны төлөвлөлт  
Гэр хорооллын дахин  
төлөвлөлт

**45,000**

Газар шинэчлэн зохион  
байгуулах төсөл

**13,500**

Ашиглалтын шаардлага  
хангахгүй барилгыг буулган  
дахин барилгажуулах төсөл

**7,746**

Орлогод нийцсэн  
орон сууцны төсөл

**38,826**

Дагуул хаяа хот, тосгод  
хөгжүүлэх төсөл

**16,512**

Орон сууцны барилга  
ашиглалтад оруулна.

Эх сурвалж: БХБЯ, 2021


УЛААНБААТАР БА  
ДАГУУЛ ХОТ

**ТӨЛӨВЛӨЛТ  
ТӨВТЭЙ  
ХӨГЖИЛ**

### ОЛОН УЛСАД ӨРСӨЛДӨГЧ МЕТРОПОЛИТАН ХОТ

Улаанбаатар хот нь сая гаруй хүн аж төрдөг метрополис хот. Цаашид эрчимтэй хөгжиж, олон улсад өрсөлдөх чадвартай метрополитан хот болно. Үүний тулд хот төлөвлөлтөд иргэдийн амьдралын чанар, өрсөлдөх чадвар, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байдал, орчин үеийн шийдэл, техник технологийн нутагшилт гээд олон шалгуурыг тооцох учиртай. Тиймээс урт хугацааны хөгжлийн бодлогодоо Улаанбаатарыг амьдралын таатай орчин бүрдсэн метрополитан хот болгон хөгжүүлэхээр тусгасан.

Зураг 11. Улаанбаатар хотын хөгжлийн тойрог





Улаанбаатар хот доторх төвлөрлийг задлах зорилгоор соёл, боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн дэд бүтцийн хангамж бүхий хотын шинэ төв, дэд бүтэц, төрөлжсөн төв, олон нийтийн төвүүдийг шинээр байгуулж, тэдгээрийг холбосон хөгжлийн коридорыг бий болгоно. Энэ бүхэнд цахим суурьтай санхүүгийн технологи, цахим банк, цахим мөнгө, хиймэл оюун ухаан, блокчэйн технологи, автоматжуулалт, үүлэн технологи, хатуу болон дэд бүтцийг нэвтрүүлсэн байна.

Иргэдийн ая тухтай байдлыг хангах зорилгоор Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн салбарыг хотоос шилжүүлэх нэгдсэн бодлого хэрэгжүүлнэ.

Мөн тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, томоохон спортын наадмыг зохион байгуулах, шаардлага хангасан, олон улсын жишигт нийцсэн 30-40 мянган хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэн барьж байгуулна. Жуулчдад зориулсан үндэсний онцлог бүхий урлаг соёлын хөтөлбөрүүдийг бий болгож, тогтмол зохион байгуулна. Сур харваа, шагай харваа, морины уралдаан гэх мэт монголын уламжлалт спортын төвүүдийг байгуулж, үндэсний багтай болох, гадаадын багийг урьж тоглуулах тогтолцоог бүрдүүлнэ. Түүх соёлын өвийг хадгалж, хамгаалах, сэргээн засварлах үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлнэ.

Дэлхийн өндөр хөгжилтэй хотууд дагуул, хаяа хотуудаа ч дагуулан хөгждөг. Энэ жишгээр Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу нийслэлийн дагуул, хаяа хот, тосгодыг хөгжүүлж, бие даан хөгжүүлнэ. Нийслэлийн төвлөрөл саарч, иргэдийн амьдралын таатай орчин бүрдсэн хот болон хөгжих юм.

## 2020

Улаанбаатар хот

## 2030

Улаанбаатар ба дагуул хотууд

## 2040


Улаанбаатар агломерац

## 2050

Улаанбаатар метрополитан

Орон зайн оновчтой бүтэц, нутагшилт суурьшлын зөв тогтолцоотой, эрчимтэй хөгжиж буй дагуул хотуудтай, эрүүл аюулгүй, амьдралын таатай орчин бүхий олон улсад өрсөлдөгч МЕТРОПОЛИТАН болон хөгжинэ.

### ХҮН АМЫН ТОО



Эх сурвалж: "Азийн хүлэг улс, Алсын хараа-2050", (2021)

УЛААНБААТАР БА  
ДАГУУЛ ХОТ

ТӨЛӨВЛӨЛТ  
ТӨВТЭЙ  
ХӨГЖИЛ

Хотын эдийн засгийн 58.4 хувийг үйлчилгээний, 41.2 хувийг аж үйлдвэр барилгын салбар, 0.4 хувийг хөдөө аж ахуйн салбар эзэлж байна.

### ХОТЫН ЭДИЙН ЗАСАГ

Монголчуудын түүхэндээ байгуулсан хамгийн том хот бол Улаанбаатар. Хотын стратеги, төлөвлөгөө, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, төсөв, орлого, зардал, үр ашиг, хувийн хэвшлийн оролцоо, иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг нэгтгэн хотын эдийн засаг гэж болно. Хотын газрын байршил хотын эдийн засагт чухал. Хотын газрыг зах зээлийн харилцаанд шилжүүлэх үйл ажиллагаа нь хотын эдийн засгийн нэг суурь юм. Хотын хөгжил, төлөвлөлт, хотын бие даах чадвар, газрын харилцаа, ядуурал, нийгмийн асуудал, орон сууцны хангамж, татвар, хотын зардал ба хөрөнгө оруулалт, орон нутгийн засаг захиргааны үйл ажиллагаагаа явуулж буй хэлбэр зэрэг бүх асуудал газрын байршлаас урган гардаг. Байршлыг хөгжлийн голлох хүчин зүйл болгож үздэгээрээ хотын эдийн засаг бусад салбараас онцлог. Зах зээл, эдийн засгийн боломж хаана байна, тэнд хот үүсдэг. Дэлхийн том хотууд өөрийн татвартай байдаг. Улаанбаатар хот өөрийн татвартай байх нь хотын эдийн засаг, нийтийн аж ахуйг авч явахад чухал хүчин зүйлд тооцогддог. Том хотод амьдрахад өртөг өндөр. Энэхүү татвараар хот хүнд ээлтэй, таатай, аюулгүй орчин бий болгон тордож, үйл ажиллагаагаа санхүүжүүлдэг.

Улаанбаатар хот өөрөө эдийн засгийн хувьд биеэ даах, хөрөнгө оруулалт татах сонирхолтой орчин байх ёстой. Хүн ам нэмэгдэх нь эдийн засгийн хувьд илүү их боломжийг нээж өгдөг. Нэг сая гаруй хүнтэй болсноос хойш л Улаанбаатар хотод олон улсын сүлжээ үйлчилгээний брэндүүд орж ирсэн жишээг дурдаж болно.

Нийслэл Улаанбаатар хотод Монгол Улсын ДНБ-ийн 65 хувь нь төвлөрч байна. Энэ хотод ажиллаж, амьдардаг иргэд, үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж ахуйн нэгжүүд хотыг бүрдүүлдэг гэсэн үг. Хотын эдийн засгийн 58.4 хувийг үйлчилгээний, 41.2 хувийг аж үйлдвэр барилгын салбар, 0.4 хувийг хөдөө аж ахуйн салбар эзэлж байна. Хэдийгээр эдийн засгийн ач холбогдол нь өндөр байгаа ч энэ төвлөрөл иргэдийн Үндсэн хуулиар олгогдсон эрхийг хангаж чадахгүйд хүргэж байна.

Тиймээс уг асуудлыг шийдэж, гэрэл гэгээтэй ирээдүйг бий болгохоор хөгжлийн төлөвлөгөөгөө тодорхойлсон. Улаанбаатар хотын дагуул, хаяа хот тосгодыг байгуулж, тэр бүхэн нь өөр өөрийн төрөлжсөн өнгө төрхтэй байх юм. Нэгэнд нь аж үйлдвэр өрнөж байхад нөгөөд нь соёл, боловсрол цэцэглэж байх болно. Дагуул, хаяа хот тосгодыг холбосон зам тээврийн сүлжээг байгуулж, тусгай замын автобус, цахилгаан соронзон тээвэр нэвтрүүлнэ. 2050 онд Монгол Улсын нийслэл Улаанбаатар




эдийн засгийн хувьд бие даасан, өрсөлдөх чадвартай эдийн засгийн чөлөөт бүс, дагуул хот, хаяа тосгодоор хүрээлэгдсэн дэлхийн метрополитан хот болох юм. Бизнес соёлын төв болсон хотод маань жуулчдад зориулсан үндэсний онцлогийг харуулсан урлаг соёлын арга хэмжээ тогтмол явагдана. Мөн сур харваа, шагай наадгай, хурдан морины уралдаан, тэмээн поло зэргээр Монголын уламжлалт спортын төвүүдийг байгуулж, үндэсний багтай болох талаар өмнө дурдсан билээ. Энэ нь Монгол Улсыг сурталчлах үүд хаалга болохоос гадна спортын төрөл бүрээр баг тамирчдыг бэлтгэх бааз суурь болж, хотын эдийн засгийг тэтгэх бас нэгэн тулгуур болно.

Улаанбаатар ба дагуул хот, хаяа тосгодын эдийн засгийн хэмжээг нэмэгдүүлж, үр ашгийг нь шударгаар, тэгш хүртээмжтэй нийтээрээ хүртэх үндэс суурийг бий болгосноор иргэдийн орлого өсөж, амьдралын чанар шинэ шатанд гарч, ирээдүйд орчин үетэйгээ хөл нийлүүлсэн хотын соёл хандлага, хэв маяг бүрдэх нөхцөл бий болох учиртай.

**Үйлдвэрлэл технологийн парк**

Шинжлэх ухааны ололт, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, орчин үеийн үйлдвэрийн дэд бүтэц, бизнесийн таатай орчин бүрдүүлсэн үйлдвэрлэл, технологийн цогцолборыг хөгжүүлнэ.

Зураг 12. Улаанбаатар хотын үйлдвэрлэл технологийн парк




Эх сурвалж: НЗДТГ, 2021

## ОЛОН ТӨВТ ХОТ

Улаанбаатар хотын төвлөрлийг багасгах зорилгоор соёл боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн дэд бүтцийн хангамж бүхий хотын шинэ төв, дэд төв, төрөлжсөн төв, олон нийтийн төвүүдийг шинээр байгуулж, тэдгээрийг холбосон хөгжлийн коридорыг бий болгоно. Улаанбаатар хотын хөгжлийн Ерөнхий төлөвлөгөөний дагуу нийслэл болон дагуул, хаяа хот, тосгоны инженерийн дэд бүтцийг үе шаттай барьж байгуулан, өргөтгөж шинэчилнэ. Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж буй үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлэх нэгдсэн бодлого хэрэгжүүлнэ.

Зураг 13. Олон төвт хот



Эх сурвалж: НЗДТГ, 2021




# ЗҮҮН ХОЙД АЗИЙН АЧАА ТЭЭВРИЙН ЗАНГИЛАА ТӨВ



Олон улсын шинэ нисэх онгоцны буудал “Богдхан” төмөр зам, олон улсын “АН-3” авто зам зэрэг үндэсний томоохон бүтээн байгуулалтын төслүүдэд түшиглэн Төв аймгийн нутагт авто, агаар, төмөр замын холимог тээврийн нэгдсэн зангилаа бий болгож, олон улсын ачаа, зорчигч тээвэр, гадаад, дотоод худалдааны урсгалыг даган эдийн засгийн чөлөөт бүс, түүх, соёлын аялал жуулчлал, орчин үеийн үйлдвэрлэл, мэдээлэл, технологийн бүсийг хөгжүүлж, хот суурины оновчтой тогтолцоог бүрдүүлэх замаар Улаанбаатар хотын бүс нутгийн эдийн засагт гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлнэ. Ингэснээрээ Улаанбаатар хотод Зүүн хойд Азийн ачаа тээврийн томоохон зангилаа төв бий болгоно.

Зураг 14. Улаанбаатарын бүсийн тээвэр, логистик



УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ

# ХОТЫН САЙН ЗАСАГЛАЛ

**ЗОРИЛТ 9.4** Хууль, эрх зүйн тогтвортой орчинтой, хотын дүрэм стандартыг хангуулсан сайн засаглалтай хот болно.

**ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ · ХҮРЭХ ҮР ДҮН**

**I ҮЕ ШАТ | 2021-2030**

Хууль, эрх зүйн шинэчлэл хийж хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэн хотын засаглал, эдийн засаг, нийгмийн таатай орчин бүрдүүлэх үе

**II ҮЕ ШАТ | 2031-2040**

Хотын тогтвортой засаглалыг бэхжүүлэх, олон улсын найрсаг харилцааны эрх зүйн орчин бүрдүүлэх үе

**III ҮЕ ШАТ | 2041-2050**

Хотын сайн засаглал, олон улсын тогтвортой харилцааг бэхжүүлэх үе



Ухаалаг засаглалын шинж байдлыг иргэдийн өргөн оролцоог хангах, хууль дээдлэх ёсонд үндэслэн шийдвэр гаргах, засгийн газрын үйл ажиллагаа ил тод явагдах, иргэдийн хэрэгцээ, сонирхлыг мэдрэх, бүх иргэдэд тэгш хандах, төсвийн зарцуулалтыг үр ашигтай, үр нөлөөтэй зарцуулах, улс төрийн хариуцлагатай байх, хөгжлийн төлөвлөлтөд алсын хараатай хандах явдал хэмээн тодорхойлсон байдаг.


**БИЕ ДААСАН ХӨГЖЛИЙН ЭХЛЭЛ**

Өнгөрсөн хугацаанд нийслэл Улаанбаатар хот хөгжлийн тодорхой түвшинд хүрсэн ч эдийн засгийн хувьд тэлэх, хөгжлийн шинэ шатанд хүргэх, дэлхийн том хотуудын жишгээр хотжиход чиглэсэн хууль, эрх зүйн орчин шаардлагатай болсон юм. Сүүлийн 30 жилийн хугацаанд хуримтлагдсан асуудлыг сууриар нь залруулах боломж Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар нээгдэв. Өнгөрсөн 2020 оны арванхоёрдугаар сарын сүүлээр батлагдсан энэ хуулиар нийслэл төсвийн орлогоо өөрөө захиран зарцуулах эрхтэй болсон юм.

УИХ-аас Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчлэн баталж, 2022 оны нэгдүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Хуулиар Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх эдийн засгийн үндэс, үйл ажиллагааны зарчим, удирдлагын эрх



Зураг 15. НЗДТГ-ын бүтэц



Эх сурвалж: НЗДТГ, 2021

зэргийг тодорхойлсон бөгөөд төвлөрлийг сааруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, замын түгжрэл, агаар, хөрсний бохирдол гэх мэт Улаанбаатар хотод тулгамддаг асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн харилцааг зохицууллаа. Дээр дурдсан хуулийн өөрчлөлтөөр Улаанбаатар хотыг хөгжлийн шинэ шатанд хүргэх эрх зүйн үндсийг тавьсан.

Ийнхүү суурь хууль, эрх зүйн орчныг шинэчилж, Улаанбаатар хотын сайн засаглалыг бэхжүүлэх замаар иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг дархлах болно. Угаас хууль засагладаг ардчилсан улс оронд нийтээр дагаж мөрдвөл зохилтой аливаа эрх зүйн соёл, төрийн үйлчилгээний мөн чанар нь иргэдийг хүнд сурталтай тулгарахгүй байхад чиглэдэг. Тиймээс цаашид хууль, эрх зүйн шинэчлэлийг тууштай, шат дараатай хийж, төрийн албаны хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлсэнээр иргэдэд түргэн шуурхай, хүртээмжтэй, цогц байдлаар төрийн үйлчилгээ үзүүлэх нийгмийн таатай орчин бүрдэх юм.

Энэ хүрээнд хотын бие даан хөгжих хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, хотын багц дүрэмтэй болж, бүс нутгийн хөгжлийн бодлоготой уялдсан салбаруудын дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулна. Хотын засаглалын оновчтой тогтолцоог бүрдүүлэн, бүх шатны төлөвлөлт, төлөвлөгөөг боловсруулах, батлах,

*Нутгийн өөрөө удирдах ёс*  
Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал бол нутгийн өөрөө удирдах байгууллага юм. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ.

УЛААНБААТАР БА  
ДАГУУЛ ХОТ

## ХОТЫН САЙН ЗАСАГЛАЛ

### ХОТЫН ДҮРЭМ ЖУРАМ

Дэлхийн хотууд дор  
бүрнээ өөрсдийн дүрэм  
журам, стандарт, соёлоо  
бий болгон иргэд нь  
нийтээрээ даган мөрддөг.

шийдвэр гаргахад иргэд, олон нийтийн оролцоог хангаж, иргэдийн мэдээлэл олж авах эрхийг хангаж, нээлттэй, хүртээмжтэй, ил тод болгоно. Хотын засаглалд төр хувийн хэвшлийн байгууллага, олон нийтийн оролцоо, түншлэлийг бэхжүүлэх, хувийн хэвшлийн байгууллагуудын нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээг дэмжиж ажиллана. Хотод үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтарч ажиллана.

Мөн хотын татварыг төрөлжүүлэх шаардлага бий. Тухайлбал, архи, согтууруулах ундаа, тамхины болон автомашины, агаарын бохирдлын онцгой албан татвар зэргээр ангилна. Түүнчлэн хотын бүсчлэл, авто замын бүсчлэл бий болгон бүсийн зэрэглэл тогтооно. Улмаар бүсчлэлийн дагуу газрын төлбөр болон үл хөдлөх хөрөнгийн татварын ялгаатай хувь хэмжээ тогтоох, төвийн бүсэд зорчих тээврийн хэрэгсэлд тодорхой нөхцөл, шаардлага тавих асуудал ч амьдралаас урган гарч байна.

Түүнчлэн хотын тогтвортой засаглалыг бэхжүүлж, олон улсын найрсаг харилцааны эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Дэлхийн улс орнууд өөр хоорондоо уялдаа холбоотой хөгжиж буй энэ үед бид зөвхөн дотооддоо бус, олон улсад үүд хаалгаа нээж хамтран ажиллах нь чухал. Төрийн "ухаалаг" үйлчилгээг нэвтрүүлсэн хотын засаглалын зүй ёсны үр дүн бол иргэдийн ажиллаж, амьдрахад таатай, олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц орчин нөхцөлийг бий болгох явдал юм.

Ингэснээр олон улсын тогтвортой харилцааг бэхжүүлнэ. Дэлхийн бусад хотууд, хөрөнгө оруулагчид, жуулчидтай хамтарч ажиллахад хотын засаглал хууль дүрэм тодорхой, ойлгомжтой, эрхийг нь хүндэлсэн байх учиртай. Улмаар гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэж, хотын эдийн засаг тэлэх, ажлын байр шинээр бий болж, иргэдийн орлого өсөхөөс гадна дэлхийтэй хийх соёлын солилцоо өргөжиж, үндэстний өвөрмөц уламжлалд түшиглэсэн хотын шинэ соёл, өнгө төрх бүрэлдэх нөхцөл болох билээ.


Хотын нийгмийн харилцаа нь маш олон талт байдлаар илэрдэг онцлогтой. Тиймээс зөвхөн төрийн байгууллагын үйл ажиллагаагаар нийгмийг бүхэлд нь удирдан зохион байгуулах бололцоо хязгаарлагдмал тул хотод тулгарч буй тодорхой асуудлыг төр, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, олон нийтийн оролцоо, түншлэлийг бэхжүүлэх замаар шийдэх хотын засаглалын оновчтой, үр дүнтэй тогтолцоог бий болгох нь чухал.



Зураг 16. Ухаалаг хотын ухаалаг шийдэл

Хотын амьдралын бүхий л салбар дахь ухаалаг хяналтын систем нь хотын цогц төлөвлөлтийн шинэ өнгө төрхийг цогцлуулахад чиглэнэ.

- Тээвэр
- Дэд бүтэц
- Хүрээлэн буй орчин
- Нийтийн хэрэглээ
- Барилга, байгууламж
- Амьдрахуй



Эх сурвалж: SmartNations Foundation (SNF)  
FOR A SUSTAINABLE WORLD, 2019

Улаанбаатар хотын хүн амын хэтийн тооцооллыг бүрэлдэхүүний аргаар Mortrak программ дээр Коэли Демикий баруун загварыг ашиглаж, төрөлтийн түвшнээс хамааруулан 3 хувилбараар, шилжих хөдөлгөөний нөлөөллийг үнэлсэн 3 хувилбараар, нийт 9 хувилбараар тооцсон. Улаанбаатар хотын хүн амын ердийн өсөлт 1.8 хувь байх боловч -0.1 хувийн шилжих хөдөлгөөний нөлөөгөөр 1.7 хувиар өсөхөөр тооцсон. Ингэснээр Улаанбаатар хотын хүн ам 2050 онд 2.5 саяд хүрэхээр байна.

### САЙН ЗАСАГЛАЛ-ШИНЭ СТАНДАРТ-САЙХАН ХОТ

Аливаа хотын хөгжил, дүр төрх тухайн хотод хэрэгжиж буй хууль, эрх зүйн орчин, хотын дүрэм, стандартаас шууд хамаардаг. Хот төлөвлөлт, хотын стандартад хороолол, хотхон төдийгүй барилга байгууламж, замын өргөн, даац, хайс хашлагын хэмжээ, өнгө, ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай зэргийг нарийн тодорхойлж хэрэгжүүлэн иргэдийн амьдралын таатай орчныг бий болгодог. Иймд хотын багц дүрэм, нэгдсэн стандарттай болж, мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, дүн шинжилгээ хийх бүтэн тогтолцоог бий болгох юм. Хууль, эрх зүйн орчны шинэчлэл, нэгдсэн дүрэм, стандарт, цахим үйлчилгээнд үндэслэн иргэн төвтэй хотын сайн засаглалыг бэхжүүлсэн байх зорилтыг тавилаа. Энэ хүрээнд төрийн байгууллагуудын менежмент, уялдаа холбоог сайжруулан, хүний нөөцийг чадавхжуулна. Мөн хотын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эдийн засаг, нийгмийн үр ашгаар эрэмбэлэн санхүүжүүлэх юм. Үүнээс гадна хөрөнгө оруулалтын сан байгуулж, нэгдсэн менежментийн тогтолцоо бүрдүүлнэ. Орон нутгийн өмчит газруудыг олон нийтийн компани (IPO) болгох замаар үр ашгийг нэмэгдүүлж, менежментийг нь сайжруулах асуудал ч багтаж байна. Ашиглаагүй үл хөдлөх хөрөнгийг үр ашигтай эзэмших, удирдах, хөгжүүлэх, эдийн засгийн чөлөөт эргэлтэд оруулах тогтолцоог бий болгоно. Улаанбаатар хотод амьдарч буй иргэд төдийгүй аялагч, жуулчид, бизнес хамтрагчдын аюулгүй байдлыг бүрэн хангасан, ухаалаг, цахим системтэй байх юм.

Зураг 17. Хотын сайн засаглал ба өгөгдөл мэдээллийн систем





Зураг 18. Ухаалаг хотын үндэс



Дээр дурдсан эрх зүй, дүрмийн шинэчлэл болон цахим шилжилт нь цогц хэрэгжсэнээр Улаанбаатар хотын иргэд дэлхийн хөгжил дэвшилтэй эн зэрэгцэж алхах боломж нөхцөл бүрдэнэ. Иргэддээ ажиллаж, амьдрах таатай орчин бүрдүүлсэн, олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц төрийн ухаалаг үйлчилгээтэй хот болон хөгжихийг зорьж байна.

Бүтээн байгуулагдаад 300 гаруй жилийн түүхийг бичиж буй Улаанбаатар хотод хүн амын хэт төвлөрлөөс үүдсэн агаар орчны бохирдол, авто замын түгжрэл, нийгмийн үйлчилгээний хүртээмжгүй байдал зэрэг сорилт бэрхшээл, тулгамдсан асуудал багагүй байна. Өнгөрсөн хугацаанд хуримтлагдсан эдгээр хүндрэл, бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд хууль, эрх зүйн орчин бүрдүүлж, шаардлагатай хөрөнгө оруулалт хийх нь зайлшгүй чухал.

Мөн хотын сайн засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн бодлогын арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ. Уг зорилтыг хэрэгжүүлэхэд хотын засаглалыг оновчтой болгох шаардлагатай. Хотын бүх шатны төлөвлөлт, төлөвлөгөөг боловсруулах, батлах, шийдвэр гаргахад иргэд, олон нийтийн оролцоог хангаж, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг бий болгох чиглэлээр үе шаттай арга хэмжээг авч хэрэгжүүлж, үр дүнд хүргэх ёстой юм. Сайн засаглалтай, амар тайван, олон улсын жишиг, стандарт мөрддөг сайхан хотыг хамтдаа бүтээхэд хүн бүрийн идэвх санаачилга, хариуцлагатай байдал чухал ач холбогдолтой билээ.

#### Хот ба бизнесийн орчин

Хотын хөгжлийн үндсэн шалгуурын нэг нь бизнесийн таатай орчныг бүрдүүлсэн байдлаар хэмжигддэг жишигтэй.

## БИЕ ДААСАН ХОТЫН ХӨГЖИЛ



Хотын бие даан хөгжих хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, хотын багц дүрэмтэй болж, бүс нутгийн хөгжлийн бодлоготой уялдсан дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ. Хотын эрүүл, аюулгүй, ногоон хөгжлийг дэмжсэн нийгэм, соёлыг бүрдүүлсэн эрх зүйн зохицуулалт бий болгоно. Иргэдийн ажиллаж, амьдрах таатай орчин бүрдүүлсэн олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц төрийн “ухаалаг” үйлчилгээтэй хотын засаглалыг төлөвшүүлнэ.



### Иргэдийн оролцоо

Нийслэл дүүрэг нь хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг нийгмийн цогцолбор юм. Нутгийн өөрөө удирдах ёсыг төлөвшүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, сайн засаглалыг хангах нь чухал юм.



## ХОТЫН ХӨГЖИЛД ИРГЭДИЙН ОРОЛЦОО



Хотын засаглалын оновчтой тогтолцоог бүрдүүлэн бүх шатны төлөвлөлт, төлөвлөгөөг боловсруулах, батлах, шийдвэр гаргахад иргэд, олон нийтийн оролцоог хангаж, иргэдийн мэдээлэл авах сувгийг нээлттэй, хүртээмжтэй, ил тод болгоно. Хотын засаглалд төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшил болон олон нийтийн оролцоо, түншлэлийг бэхжүүлж, хувийн хэвшлийн хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг дэмжинэ. Мэдээллийг цахимжуулж, иргэдэд төрийн үйлчилгээг цахимаар хүргэж, иргэнээ дээдэлсэн төрийн үйлчилгээний тогтолцоог бий болгож бэхжүүлнэ. Цахим засаглалын технологийг бүх түвшинд бүрэн хэрэгжүүлж, авлига хүнд сурталгүй төрийн үйлчилгээг төлөвшүүлнэ.



### Өөрийн дүрмийг төлөвшүүлнэ

Орчин үеийн хотын хөгжлийн үзэл санаа нийтээр хэлэлцэгдэн дэмжигдсэн дүрэм, шинэ стандарт жишиг болжээ. Шинэ эко орчин, хэмнэлттэй зарчим, цэмцгэр гудамж, цэцэрлэгт хүрээлэн, бичил орчин, анхан шатны үйлчилгээ бүхэн энэхүү дүрмээр зохицуулагдаж байна.

УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ

# ДАГУУЛ ХОТ

**ЗОРИЛТ 9.5** Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд Азийн тээвэр, логистикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлнэ.

**ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН**

**I ҮЕ ШАТ | 2021-2030**


Хөрөнгө оруулалтын шинэ боломж бүрдүүлж, үйлдвэрлэлийн бүс нутгийг тэлэх үе

**II ҮЕ ШАТ | 2031-2040**

Нутагшилт суурьшлын зөв тогтолцоотой, эдийн засгийн төрөлжилтийг эрчимжүүлэх үе

**III ҮЕ ШАТ | 2041-2050**

Олон улсад өрсөлдөхүйц эрчимтэй хөгжлийн үе



Дагуул хот нь нийслэл хотын төвлөрлийг сааруулж, иргэдийг тархаан суурьшуулах үүрэгтэй шинэ суурьшлуудыг бий болгох хот төлөвлөлтийн бодлого билээ. Хотын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд өөр хоорондоо уялдаатай эдийн засгийн хувьд төрөлжсөн, бие даасан дагуул, хаяа хот, чөлөөт бүсүүд байгуулах юм.


**ТӨРӨЛЖИН ХӨГЖИХ ДАГУУЛ ХОТУУД**

Төвлөрөл, түүнээс улбаатай бэрхшээлүүд болох түгжрэл, агаар орчны бохирдол, нийгмийн суурь үйлчилгээ болон инженерийн дэд бүтцийн хүртээмжгүй байдлыг багасгаж ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үр дүнтэй аргуудын нэг нь дагуул хот, хаяа тосгодыг байгуулж, хотын хүн амыг тархаан суурьшуулах юм. Харин хүн амыг тархаан суурьшуулахад ажлын байрны хүртээмж, орлого олох боломж, амьдрахад тухтай орон байр, хүүхдийн сурч, хүмүүжих орчинг бүрдүүлэх нь нэн тэргүүний ажил. Эдгээр хүчин зүйлс, хэрэгцээ үгүй бол хээр талд хөрөнгө дэмий цацах эрсдэлтэй.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Улаанбаатар хотыг дагуул долоон хот, хаяа найман тосгонтой байхаар тусгасан. Дагуул хот, хаяа тосгодыг хөгжүүлэх төлөвлөгөө ч бэлэн болсон. Нийслэлийн алслагдсан дүүргүүдийг аж үйлдвэрийн парк болгон хөгжүүлж, шинэ суурьшлын бүсүүдийг бий болгосноор



Зураг 19. Хотын төрөлжсөн хөгжил



Улаанбаатарын хүндрэл, бэрхшээлийг үе шаттай шийдвэрлэх боломжтой хэмээн үзэж байна. Иймд дагуул, хаяа хот, тосгодыг эдийн засгийн чиглэл бүрээр төрөлжүүлэн, дагнан хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулсан. Тухайлбал, эдгээр бүс нутгууд нь хүн ам суурьшсан, зарим үйлдвэрлэл, үйлчилгээ явагдаж эхэлсэн. Өөрөөр хэлбэл дагуул хот болгон хөгжүүлэх суурь нөхцөл бүрдсэн тул цаашид хөгжүүлэх шаардлагатай. Тиймээс дагуул болон хаяа хот тосгодод хөрөнгө оруулалтын шинэ боломжийг нээж, үйлдвэрлэлийн бүс нутгийг тэлэх бодлого баримтална. Энэ хүрээнд тухайн хотуудад инженерийн шугам сүлжээ байгуулж, орон сууцжуулах ажлыг үе шаттайгаар хийнэ. Дагуул хот, хаяа тосгодод төрийн үйлчилгээ төвлөрүүлэхээс гадна тухайн бүсэд суурьшин амьдрах боломж бүрдүүлэх зорилгоор сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэргийг байгуулж, инженерийн дэд бүтцийг шийдэж, ажлын байрыг бий болгох юм. Тухайлбал, Налайх, Хонхорын суурьшлын бүсэд эхний ээлжид 2,500 ажлын байр бий болгох төлөвлөгөөтэй байна. Ийнхүү төлөвлөлтийн дагуу нэн тэргүүнд хүний амьдралын таатай орчин бүрдүүлэхийг зорьж байна.

Эх сурвалж: НЗДТГ, 2021

**Хот ба дагуул хот**

Хотын өдөр тутмын хэрэгцээ, амьдралын хэмнэлд дагуул хотын гүйцэтгэх үүргийг шинээр авч үзнэ.

УЛААНБААТАР БА  
ДАГУУЛ ХОТ

## ДАГУУЛ ХОТ

Нутагшилт суурьшлын зөв тогтолцоотой, эдийн засгийн төрөлжилтийг эрчимжүүлнэ. Аж үйлдвэр, боловсрол, эрүүл мэнд, аялал жуулчлал, амралт зугаалга, худалдаа үйлчилгээ, хөдөө аж ахуй зэргээр төрөлжүүлж, эдийн засгийн үр өгөөж нэмэгдүүлнэ.

Шинээр байгуулагдах дагуул, хаяа хот, тосгодоод өндөр технологийн үйлдвэрүүдийг нутагшуулж, дэлхийн зах зээлд өрсөлдөх боломжтой эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулна. Шинэ техник, технологи, инновац шингэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлнэ. Үндэстэн дамнасан корпорацууд болон олон улсын байгууллагуудын салбар нээгдэх боломж бүрдэх юм.

Зураг 20. Шинэ дагуул хотуудын хөгжлийн нэгдсэн төлөвлөлт

**ШИНЭ ТӨЛӨВЛӨЛТ**  
Улаанбаатар хотын төвлөрлийг бууруулах нэг алхам нь дагуул хотуудыг байгуулж, тэдгээрийг эдийн засгийн хөшүүрэгтэй болгох явдал юм.



Ингэснээр олон улсад өрсөлдөх, эрчимтэй хөгжлийн үед шилжиж, дагуул, хаяа хот, тосгодоо байгуулж, эдийн засгийн чиглэлүүдийг төрөлжүүлэх юм. Илүү их хөгжил, илүү том боломжийн төлөө Монгол гэсэн тодотголтой дэлхийд танигдсан бизнес, үйлчилгээг бий болгож, олон улсад өрсөлдөх том зорилтыг тавьж байна.

Найрамдалт хотуудтай эдийн засгийн интеграцид нэгдэх замаар гадаад худалдааны шинэ боломжуудыг нээж, худалдааны шинэ сүлжээг бий болгоно. Газарзүйн байршлын давуу талаа ашиглаж, олон улсын мэдээллийн дата төвийг байгуулна.



*Дагуул хот*

Хотын хангамжийг бүрдүүлэгч нэгж болохын хувьд дагуул хотод бизнесийн орчин бүрдүүлэх, шийдлийг зөв төлөвлөх хэрэгтэй.

### УЛААНБААТАРЫН ДАГУУЛ ХАЯА ХОТ

Улс, бүс нутгийн хөгжилтэй уялдсан газар зүй, орон зайн зөв төлөвлөлт, суурьшлын оновчтой шийдэл бүхий нийслэл хот, түүнийг тойрсон дагуул, хаяа хот суурингууд хөгжинө. Улаанбаатар хотыг тойрон тодорхой чиглэлийн үйлдвэрлэл үйлчилгээ дагнан хөгжсөн дагуул хот суурингууд бүхий харилцан уялдаатай хот байгуулалт бий болно. Төрөлжин хөгжсөн дагуул хот суурингууд нь үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр хотын иргэдийн хангамжийг нийлүүлэхээс гадна төвлөрлийг задалж, суурьшлыг тэнцвэржүүлэн зам тээвэр, логикийн үйлчилгээ, инженерийн дэд бүтцийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэн тэгш, тэнцвэртэй хөгжих болно.

Хот суурингуудын хилийн цэсийг тогтооход төлөвлөлтийн хүн ам, нийгэм, эдийн засаг, үйлдвэрлэл үйлчилгээний төрөл, хөгжлийн үүрэг, чиглэл, барилгажилтын давхаржилт, суурьшлын дундаж нягтрал зэрэг хот байгуулалтын үзүүлэлтүүдийг харгалзан нийслэлийн хотжих боломжтой нутаг дэвсгэрийн газар ашиглалтыг оновчтой, үр ашигтай болгоно.

#### Жаргалант тосгон

Суурьшлын хязгаар: 391.9 га  
Санал болгож буй төлөвлөлтийн хил: 1,306.2 га  
Зөрүү: 914.3 га  
Үүрэг чиглэл:  
- ХАА  
- Агуулах, зоорь  
- ЖДУ, хүнсний үйлдвэр

#### Рашаант тосгон

Суурьшлын хязгаар: 362.7 га  
Санал болгож буй төлөвлөлтийн хил: 829.4 га  
Зөрүү: 466.7 га  
Үүрэг чиглэл:  
- Өрхийн АА, ХАА, ЖДУ  
- Шатах, тослох материалын агуулах

#### 361-н гарам

Суурьшлын хязгаар: 2,421.3 га  
Санал болгож буй төлөвлөлтийн хил: 1,468.9 га  
Зөрүү: -952.4 га  
Үүрэг чиглэл:  
- Ферм, Хүлэмж, ХАА, ЖДУ  
- Түгээлтийн төв  
- Оюутны хотхон: 10.0 мянга (хөдөө аж ахуй)  
- МБСБ (2,000 оюутан)

#### Эмээлт хот

Суурьшлын хязгаар: 5,941.9 га  
Санал болгож буй төлөвлөлтийн хил: 7,609.1 га  
Зөрүү: 1,667.1 га  
Үүрэг чиглэл:  
- Эмээлт хөнгөн үйлдвэрийн парк  
- Малын гаралтай түүхий эдийн агуулах худалдаа  
- Хөдөө аж ахуй (хүнс, түүхий эд)  
- Зоорь, агуулах  
- ЖДУ, барилгын материалын үйлдвэрлэл  
- Авторесайклинг  
- МБСБ (3,000 оюутан)

#### Туул, Био-Сонгино


Суурьшлын хязгаар: 4,884.8 га  
Санал болгож буй төлөвлөлтийн хил: 4,622.6 га  
Зөрүү: -262.1 га  
Үүрэг чиглэл:  
- Био технологийн үйлдвэр  
- Фермын АА (тахиа)  
- Хүлэмж, зоорь, агуулах  
- Амралт, аялал жуулчлал  
- ЖДУ  
- Хог шатаах үйлдвэр  
- МБСБ (3,000 оюутан)

#### Өлзийт

Суурьшлын хязгаар: 1,219.8 га  
Санал болгож буй төлөвлөлтийн хил: 1,281.5 га  
Зөрүү: 61.6 га  
Үүрэг чиглэл:  
- Хүлэмж, ферм  
- Эрчимжсэн мал аж ахуй

#### Зуслан


Суурьшлын хязгаар: -  
Санал болгож буй төлөвлөлтийн хил: -  
Зөрүү: -  
Үүрэг чиглэл:  
- Зуслан  
- Амралт, сувилал



- Нийслэлийн хил
- Төлөвлөж буй хот, тосгоднын хил хязгаар
- Одоо байгаа Олон улсын чанартай автозам
- Одоо байгаа Улсын чанартай автозам
- Төлөвлөж буй бүсийн чанартай автозам
- Одоо байгаа төмөр зам
- Одоо байгаа хурдны автозам
- Төлөвлөж буй ачаа тээврийн боодхон төмөр зам
- Төлөвлөж буй бүсийн зорчигч тээврийн хөнгөн галт тэрэг /LRT/ Дундговь

#### Шинэ Зуунмод /Аэросити

Суурьшлын хязгаар: 12,000 га  
Санал болгож буй төлөвлөлтийн хил: 19,390 га  
Зөрүү: -  
Үүрэг чиглэл:  
- Нисэх буудал  
- Эдийн засгийн чөлөөт бүс  
- Олон улсын логикийн нэгдсэн төв  
- Хуурай боомт  
- Карго төв  
- Өндөр технологийн үйлдвэрлэл  
- Тээврийн дээд сургуулийн хотхон - 2,000 оюутан



Зураг 21. Шинэ Улаанбаатар

Хот, дагуул хотын оршин суугчдын амьдралын орчныг сайжруулж, байгаль орчинд ээлтэй, ногоон хот болох зорилтын хүрээнд хотын нутаг дэвсгэрт байгалийн задгай ногоон орон зайг нэмэгдүүлэх, хяналтгүй тэлэлтийг хязгаарлах шаардлагатай тул хотын хилийн цэсийг шинэчлэн тогтооно.

Эх сурвалж: НЗДТГ, 2021



УЛААНБААТАР БҮСИЙН  
НУТАГ ДЭВСГЭР  
**470,444 га**

Улаанбаатар хотын бүсийн хэмжээнд өндөр технологийн үйлдвэрүүдийг нутагшуулж, дэлхийн зах зээлд өрсөлдөх боломжтой эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулна. Аж үйлдвэрийн бүсүүдийг салбар чиглэл бүрд төлөвлөн, кластер байдлаар дагуул хотуудыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалт татахын тулд үйлдвэр технологийн паркуудын газрыг худалдах, түрээслэх замаар эзэмшүүлнэ.

Дагуул хот, хаяа тосгодыг хөгжүүлэх бодлого хэрэгжсэнээр хүний болон хотын хөгжлийн үзүүлэлт (индекс)-ээр 1-2 байраар урагшилна гэж үзэж буй юм. Дагуул хот суурингууд нь үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр төрөлжин хөгжиж, Улаанбаатар хотод ирж буй ачаалал, төвлөрлийг задалж, нийслэл хотын хэмжээнд суурьшлыг тэнцвэржүүлэн, зам тээвэр, логистикийн үйлчилгээ, инженерийн дэд бүтцийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэн тэгш, тэнцвэртэй хөгжүүлэх боломжийг бий болгох юм.

Улаанбаатарын дагуул хотын нэг нь Шинэ Зуун мод хот. Хөшигийн хөндийд бүтээн байгуулагдсан Чингис Хаан олон улсын нисэх буудлыг түшиглэн байгуулагдах энэ хот Монгол Улсын тээвэр, логистикийн гол төв болох юм. Түүнчлэн Зүүн хойд Азийн зорчигч, агаарын тээврийн нэгдсэн зангилаа төв болгон хөгжүүлнэ. Эхний ээлжид шинэ хотын инженерийн шугам сүлжээ, орон сууцжуулах ажлыг үе шаттайгаар эхлүүлж байна.

Шинэ Зуун мод хотыг

1. Агаарын тээвэр
2. Логистик
3. Чөлөөт бүс
4. Хуурай боомт гэсэн дөрвөн чиглэлээр дагнан хөгжүүлэх юм.

Уг хот нь Улаанбаатар хотын төв цэгээс 53 км-т Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд, Төв аймгийн төв Зуунмод хотоос 10 км, Сэргэлэн сумын төвөөс 15 км, Майдар хотоос 20 км зайд байрлана. Усны нөөцийн судалгаагаар Шинэ Зуун мод хотод 150-200 мянган хүн суурьшин амьдрах боломжтой тооцоо гарсан. Иймээс Хөшигийн хөндийд Зүүн хойд Азийн зам тээврийн томоохон зангилаа төв бий болж, эдийн засгийн өсөлтөө хангасан, 150-200 мянган хүн амтай орчин үеийн аеротрополис хот байгуулагдсан байх юм. Энэ хот байгуулагдсанаар Улаанбаатар хотын төвлөрөл тодорхой хувиар буурна.

Богдхан төмөр зам, чөлөөт бүс, тээвэр логистикийн төв, 20 мянган айлын орон сууцыг барьж, 60-70 мянган шинэ ажлын байрыг бий болгосноор Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг 10-15 хувиар тэлэх боломжтой хэмээн тооцсон. Мөн олон улсын нисэх буудлыг түшиглэсэн энэ хотод олон улсын дээд хэмжээний



уулзалт, арга хэмжээг зохион байгуулах цогцолбор байгуулж, үйлчилгээний менежмент, аюулгүй байдлыг хангах тогтолцоог бий болгоно.

Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулж, нийгэм, эдийн засаг, хотын соёл, улсын хөгжилд шинэчлэл авчрах өөр нэг дагуул хот нь Майдар. Тус хотыг:

1. Аялал жуулчлал
2. Соёл боловсрол, шашин, шинжлэх ухааны гол бүс нутаг болгон хөгжүүлэхээр төлөвлөсөн.

Улаанбаатар хотын төвлөрлийг задлах зорилготой энэ хотын хэтийн төлөв нь нийгэм, эдийн засгийн хувьд бие даасан, дагнасан хөгжилтэй дагуул хот болох юм. Майдар хот Монгол Улсын нүүр царай болох учиртай. Энэ хотод соёлын аялал жуулчлал, бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, соёл урлагийн зах зээлийг хөгжүүлэхэд салбар хоорондын уялдаа холбоог сайжруулна. Мөн төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд аялал жуулчлалын томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ. Хөдөө орон нутгаас нийлүүлдэг органик бүтээгдэхүүн болон Монгол брэндийн бүтээгдэхүүний худалдааны сүлжээг өргөтгөнө.

Майдар хотын өөр нэг дүр төрх нь соёл урлаг, спорт учир жуулчдад зориулсан үндэсний онцлог бүхий урлаг соёлын хөтөлбөрүүдийг бий болгож, тогтмол зохион байгуулна. Түүгээр зогсохгүй дэлхийн хэмжээний соёл урлагийн фестивал наадмуудыг зохион байгуулна. Майдар хотыг Зүүн хойд Азид хүлээн зөвшөөрөгдсөн соёл, шинжлэх ухааны төв болгон хөгжүүлэх бодлого баримтална.

Үүнээс гадна Майдар хотод олон улсын, тив, дэлхийн томоохон наадмыг хүлээн авч зохион байгуулах шаардлага хангасан спортын барилга байгууламжийг барина. Зөвхөн соёл урлагийн бус спортын олон улсын тэмцээн уралдааныг ч зохион байгуулах боломж бүрдэнэ гэсэн үг.

Мөн энэ хотод их, дээд сургуулийн томоохон оюутны хотхонууд байгуулагдана. Нийслэлд төвлөрч буй их, дээд сургуулийг мэргэжлийн чиглэл, салбараар нь төрөлжүүлж, оюутны сурч боловсрох бүхий л нөхцөлийг хангасан оюутны хотхон байгуулна.

Майдар залуучуудын ажил амьдрал буцалсан, аялагч жуулчдад нээлттэй, урлаг соёл, спортын арга хэмжээ тасралтгүй үргэлжилсэн хөгжингүй хот болон хөгжих юм.

#### *Өөрийн онцлогтой дагуул хот*


Хотын тодорхой чиг үүргийг хангахаас гадна газарзүйн байршил, дэд бүтцийн сүлжээ, өвөрмөц онцлогоос хамаарч дагуул хот бие даасан чиглэлээр хөгжиж болно.

### ХАЯА ТЭЛЭН ХӨГЖСӨН УЛААНБААТАР

Өдгөө дэлхийн аялал жуулчлал, худалдаа, эдийн засгийн гол төв болоод буй БНХАУ-ын Шанхай хот хөх мөрний эрэг дагуу шинэ Шанхай, хуучин Шанхай хэмээн нэрлэгдэн, өдөр өдрөөр хөгжсөөр байна. Шанхай хот өнөөгийн Улаанбаатарын адил төвлөрлийн түмэн бэрхшээлтэй тулгарч, хотоо дахин төлөвлөхөөс өөр аргагүй байдалд орсон. Ингэхдээ хуучин Шанхайн дүр төрхийг хэвээр үлдээж, Хятадын түүх соёлын төв болгон аялагч жуулчдыг татсан бол Шинэ Шанхайг дэлхийн худалдаа, эдийн засгийн гол төв болгож, “Дорнын Нью Йорк” гэж нэрлэгдэх хэмжээнд хүргэн хөгжүүлсээр байна.

Улаанбаатарыг ийм замаар хөгжүүлэх боломж ч бий. Өнөөгийн Улаанбаатарыг бизнес, соёлын төв болгон хөгжүүлж, тойрон хүрээлэх дагуул хотуудыг аялал жуулчлал, нийгэм, эдийн засаг, боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр дагнан хөгжүүлж, бие даасан хотууд болгох бүрэн боломжтой. Улаанбаатар хотын

Зураг 23. Дагуул хаяа хот, тосгон



Эх сурвалж: НЗДТГ, 2021



хэмжээнд бүтээн байгуулалт өрнүүлж, гэр хорооллыг дахин төлөвлөн, орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ.

Засгийн газар өндөр технологи, мэдлэгт суурилсан үйлдвэрлэлийг дэмжиж хөгжүүлэх зорилт тавьсан. Шинэ суурьшил, дагуул хотуудад аж үйлдвэрийн шинэ хувьсгалыг эхлүүлснээр импортыг орлох бүтээгдэхүүнийг дэмжин, гадаад зах зээлд Монгол брэндийг таниулах боломж бий. Мөн энэ нь ажлын байрыг бий болгож, иргэдийн зохистой шилжилт хөдөлгөөн, нутаг дэвсгэрийн тэнцвэртэй хөгжлийг бий болгох олон талын ач холбогдолтой.

Ийнхүү Улаанбаатар хот маань хаяа тэлэн хөгжиж, олон улсад нэр хүндтэй соёл, бизнесийн төв болж, жуулчдын аялах дуртай газар, гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчин бүхий соёлч, боловсон ард иргэд нь тайван жаргалтай, элбэг хангалуун, амьдралын чанар өндөр, хотын ухаалаг засаглал, алсын хараатай, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь үр дүнтэй, олон нийтийн оролцоо, хяналт тавих боломжоор бүрэн хангагдсан зэрэг ирээдүйн дэлхийн хотуудад жишиг болохуйц сайн сайхан "шинэ" хотыг хамтдаа бүтээх болно.


#### *Хотын тэлэлт*

Хот хөгжихийн хэрээр хүн амын шилжин ирэлт нэмэгдэн тэлэлт шаарддаг. Ялангуяа төлөвлөлт шилжин ирэлтийн эрчмээс хоцорсон тохиолдолд тэлэлтийг огцом хийх шаардлага үүсдэг байна. Иймд хотын тэлэлтийг урьдчилан төлөвлөх хэрэгтэй.

## ХӨШИГИЙН ХӨНДИЙ

Дагуул, хаяа хот тосгод бүрийг худалдаа үйлчилгээ, соёл боловсрол, хөдөө аж ахуй, хүнс хөнгөн үйлдвэрлэл, тээвэр логистик, аялал жуулчлалын чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулна. Майдар, Хөшигийн хөндийд байрлах олон улсын нисэх буудлыг даган байгуулагдах Шинэ Зуун мод шинэ дагуул хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, инженерийн шугам сүлжээ, орон сууцжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, Зүүн хойд Азийн зорчигч, ачаа тээврийн нэгдсэн зангилаа төвийг байгуулах эхлэл тавигдах юм.

Зураг 24. Хөшигийн хөндийн чөлөөт бүс





# БОГДХАН ТӨМӨР ЗАМ



Богдхан төмөр зам нь Улаанбаатар хотын Багахангай, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн газар нутгийг дамжин, нийт 135.8 км үргэлжлэх юм. Богдхан төмөр зам ашиглалтад орсноор Монгол Улсын дэд бүтцийн тээвэр логистикийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, шинэ дагуул хотууд бий болох, ажлын байр нэмэгдэн, хүн амын төвлөрөл саарч, улмаар агаар, хөрсний бохирдол буурна. Түүнчлэн төмөр замын тээх, нэвтрүүлэх хүчин чадал нэмэгдэж, нийслэл дэх хөдлөх бүрэлдэхүүний чимээ багассанаар нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдэх юм.

## ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨЛТӨД ТУССАН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТУУД



## ҮР ДҮН

**150 мян**

Иргэн

**10%**

Агаар, орчны бохирдол буурна



Валютын эх үүсвэр төрөлжинө



Төмөр замын ачаа эргэлтийн хэмжээ, хурд нэмэгдэнэ



Хөрөнгө оруулалтын орчин бүрдэнэ

**50 мян**

Өрх

**20%**

Хүн амын нягтрал буурна

**20%**

Замын түгжрэл буурна



УБ-аар дамжин өнгөрөх машины урсгалыг бууруулна



Худалдаа, аялал жуулчлалын орлого нэмэгдэнэ

### ЭХ СУРВАЛЖ, АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Монгол Улсын Засгийн Газар. (2021). "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн танилцуулга. УБ.
- Барилга, Хот Байгуулалтын Яам. (2021). Салбарын танилцуулга. УБ.
- Монголын Эдийн Засгийн Форум. (2022). Улаанбаатар хотын хэт төвлөрөл. УБ.
- Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар. (2021). Улаанбаатар хотыг 2040 оны хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө. УБ.
- Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар. (2022). Бүтэц зохион байгуулалт. Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар: <https://zdtg.ulaanbaatar.mn/more/9>
- Л.Оюун-Эрдэнэ. (2021). Азийн хүлэг улс, Алсын хараа-2050. УБ.
- Эрчим Хүчний Яам. (2022). Салбарын танилцуулга. УБ.
- Боловсрол, Шинжлэх ухааны яам, Үндэсний Статистикийн Хороо. (2021). "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны бодлогод суурилсан Боловсролын салбарын хэтийн тооцоо. УБ.
- Smart Nations Foundation (SNF) FOR A SUSTAINABLE WORLD . (2019). SMART SOLUTIONS FOR SMART CITIES. <https://www.smartnations.com/smart-solutions-for-smart-cities/>

### ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
АҮП	Аж үйлдвэрийн парк
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
МАА	Мал аж ахуй
МХХТ	Мэдээлэл харилцаа холбооны технологи
МБСБ	Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
УИХ	Улсын Их Хурал
УБХЕТ	Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө
ҮТП	Үйлдвэрлэл технологийн парк
ХАА	Хөдөө аж ахуй
ЦС	Цахилгаан станц
ЭХЯ	Эрчим хүчний яам